

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Хүү, торгуулийн орлогыг үндэслэлтэй төлөвлөх эрх зүйн орчин нөхцөл бүрдээгүй байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д
хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: НТАГ-2025/27-ШТА-ГА

Чойбалсан хот
2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
Аудитор С.Төмөрхуяг
Утас: 7058-4207, Цахим хаяг: tumurkhuyags@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4

БҮЛЭГ А. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН НӨХЦӨЛ БҮРДЭЭГҮЙ БАЙНА.....6

A.1 Хүүгийн орлогыг зээлийн гэрээнд заасан хүүгийн хувь хэмжээг үндэслэн төлөвлөж байгаа бол торгуулийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд төлөвлөж байна.....	6
A.1.1 Хүүгийн орлогыг бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлж төлөвлөх эрх зүйн зохицуулалт байхгүй байна.....	6
A.1.2 Торгуулийн орлогыг төлөвлөх бодит хэрэгцээ шаардлага байна.....	7
A.2 Хүү, торгуулийн орлогыг төлөвлөхдөө орлого бүрдүүлдэг байгууллагуудын зөрчлийн тоо хэмжээ, хэрэгжилт зэрэг суурь судалгаа гаргаагүй, давсан болон дутсан нөхцөл байдлыг үнэлж дүгнээгүй байна.....	7
A.2.1 Торгуулийн орлогын биелэлт 2023 онд 92.6 хувь, 2024 онд 144 хувийн биелэлттэй байна.....	7
A.2.2 Торгуулийн орлогыг төлөвлөхдөө орлого бүрдүүлдэг байгууллагуудын зөрчлийн тоо хэмжээ, хэрэгжилт зэрэг суурь судалгаагүй зөвхөн өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна.....	8
A.2.3 Хүүгийн орлогыг ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг харгалзан тооцож төлөвлөөгүй байна.....	9
A.2.4 Торгуулийн орлогоос авто замын санд зарцуулах зардлыг хууль, тогтоомжийн дагуу тооцоолоогүй байна.....	9-10
A.2.5 Хүү, торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан нөхцөл байдлыг үнэлж дүгнээгүй байна.....	11
A.2.6 Орлогын эх үүсвэрийг үнэн зөв тооцоолох эрх зүйн орчин бүрдээгүй байна.....	11
A.3 Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлттэй холбоотой эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.....	12
A.3.1 Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчинд харилцан уялдаагүй заалтууд байна.....	12
A.3.2 Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчлагдаагүй байна.....	13
A.3.3 Хууль тогтоомжид хүү, торгуулийн орлогыг төлөвлөх хуваарилах талаар тодорхой зааж өгөөгүй нь орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.....	13
A.3.4 Зөрчлийн тухай хуулийн 11.9.2 болон 14.7.41, 47 дахь заалтад тусгасан торгуулийн хэмжээ үйлдсэн зөрчилтэй нь нийцэхгүй байна.....	14-16
A.3.5 Хуулийн хэрэглээ нь бүх нийтэд харилцан адилгүй үйлчилж байна.....	17-18
A.3.6 Орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байна.....	19
A.3.7 Хүү, торгуулийн орлого нь иргэний өмчийн халдашгүй байдалд шууд зөрчилдөөгүй бөгөөд хуулийн хүрээнд хязгаарлаж байна.....	19
Б.1. УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХЭЭР НОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БИЕЛЭЛТ 61.7 ХУВИЙН БИЕЛЭЛТТЭЙ БАЙНА.....	20
B.1.1 Хууль, журмын дагуу тогтоосон торгуулийн орлого 61.7 хувийн биелэлттэй байна.....	20
B.1.2 Торгуулийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан тогтоож байна.....	21
B.1.3 Орлого бүрдүүлэлтийг санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд бүрэн тусгаж тайлагнасан байна.....	21
B.1.4. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт нь төсвийн орлогын бусад эх үүсвэрт нөлөөлөхүйц хувийг эзлэхгүй байна.....	22
B.2. Торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023 онд 63.3 хувиар, 2024 онд 66.7 хувиар тус тус дутуу хөрөнгө хуваарилсан байна.....	22
B.2.1 Төсвийг хуваарилах эрх бүхий байгууллага бүрэн эрхийн хүрээнд төсвийг баталж байна.....	22
B.2.2 Торгуулийн орлогыг хуваарилахдаа баталсан хууль тогтоомжид нийцүүлж хуваарилахгүй байна.....	
B.2.3 Торгуулийн орлогыг зориулалтын дагуу хуваарилсан байна.....	23

Б.2.4. Орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг харгалзан үздэггүй байна.....	24
В.1 ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ АВТО ЗАМЫН САН, ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛД ЗАРЦУУЛСАН БАЙНА.....	24
В.1.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023-2024 онд 517.5 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан ч гэмт хэрэг гаралтын тоо өссөн дүнтэй байна.....	24-26
В.1.2 Хүү, торгуулийн орлогыг эдийн засгийн ангиллаар зарцуулсан байна.....	27
В.1.3 Торгуулийн орлогоор санхүүжүүлсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, сумдад тэгш хүртээмжтэй хүргээгүй байна.....	27-28
В.1.4 ГХУСАЗСЗ-ийн хэрэгжүүлж буй ажил нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлж чадахгүй байна.....	29
В.2 Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг олон нийтэд шилэн дансны цахим хуудсаар мэдээлж ажилласан байна.....	30
В.2.1 Шилэн дансны цахим хуудсанд хүү, торгуулийн орлогыг 2024 оноос эхлэн зөв дүнгээр мэдээлсэн байна.....	30
В.2.2 Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансны цахим хуудсанд мэдээлснээс бусдаар олон нийтэд хүргээгүй байна.....	30
В.2.3 Иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талууд хүү, торгуулийн орлогын зарцуулалттай холбоотой ил тод байдалд үнэлгээ өгч, санал хүргүүлээгүй байна.....	31
БҮЛЭГ Г. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН НЭГДСЭН БҮРТГЭЛИЙН САН БҮРДЭЭГҮЙ, ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨ СУЛ БАЙГААГААС ОРЛОГО ТӨВЛӨРӨЛТ ДУТУУ, ЗАРЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДЛЫГ НЭГТГЭН ХЯНАХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.....	32
Г.1 Хүү, торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан байхгүйгээс шалтгаалан нийт хэдэн торгууль ногдуулж, хэрэгжилтийг бодитой, нэгтгэсэн байдлаар хянах боломжгүй байна.	
Г.1.1 Байгууллага хооронд мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй.....	32
Г.1.2 Торгуулийн төлбөрийн систем бүрэн хэрэгжихгүй байна.....	33
Г.1.3 Хяналтын систем нь бүрэн хөгжөөгүйгээс орлого бүрдүүлэлтийн үр дүнд нөлөөлж байна.....	34
Г.2. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГААС ХЯНАЛТ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА.....	35
Г.2.1 Хугацаа хэтэрсэн торгуулийн орлогыг барагдуулахаар зохион байгуулсан ажлын үр дүн хангалтгүй байна.....	35
Г.2.2 ГХУСАЗСЗ нь ажлын тайлангаа ИТХ-д танилцуулснаас бусдаар эрх бүхий байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй байна.....	36
Г.2.3 Торгууль ногдуулсан 26 байгууллагаас 4 байгууллагын торгууль бүрэн хэрэгжээгүй байна.....	37
Г.2.4 Иргэн, ТББ, ОУБ-аас хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтад хөндлөнгийн хяналт хэрэгжүүлээгүй байна.....	38
 ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....	39-41
ДҮГНЭЛТ:	42
САНАЛ:	43
ЗӨВЛӨМЖ:	44
АЛБАН ШААРДЛАГА.....	45-47
ТУШААЛ.....	48-49
ХАВСРАЛТ.....	50

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын стандарт
АЗД	Аймгийн Засаг дарга
ААН	Аж ахуй нэгж
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ГХЗУСТХ	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
ЗГ	Засгийн газар
ЗЦ	Замын цагдаа
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗтХ	Зөрчлийн тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ШТА	Шууд тайлагнах аудит
MNS	Mongolian national standard
НДГ	Нийгмийн даатгалын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОУБ	Олон Улсын байгууллага
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХДАГ	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар
ТЕХ	Татварын ерөнхий хууль
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийлээ.
Аудитын зорилт	Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Нийслэл дэх аудитын Төрийн газарт болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх; • Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх; • Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх; • Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын холбогдох чиг үүргийн хэрэгжилт, 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, зарцуулалт, хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, материалыг хамруулж аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 200, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, судалгаа явуулах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг, С.Төмөрхуяг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ. Аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 8 дугаар сарын 07-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж хэлэлцүүлэн, тайланг 8 дугаар сарын 22-нд Нийслэл дэх төрийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

БҮЛЭГ А. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН НӨХЦӨЛ БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

А.1 Хүүгийн орлогыг зээлийн гэрээнд заасан хүүгийн хувь хэмжээг үндэслэн төлөвлөж байгаа бол торгуулийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд төлөвлөж байна.

А.1.1 Хүүгийн орлогыг бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлж төлөвлөх эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Төрийн байгууллагууд нь хүүгийн орлогыг төлөвлөх хэрэгцээ шаардлагын талаар судалгаа гаргадаггүй байна. Энэ нь хүүгийн орлогыг бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлж төлөвлөх талаар эрх зүйн зохицуулалт байхгүйтэй холбоотой байна.

Хүүгийн орлогыг зээлийн гэрээнд заасан хүүгийн хувь хэмжээг үндэслэн эргэн төлөлтийн орлоготой уялдуулан төлөвлөж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүүгийн орлогыг 2023 онд 1,736.5 сая төгрөгөөр, 2024 онд 224.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Энэ нь Сангийн яамнаас дэд бүтцийн чиглэлээр “Дорнод Нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ-т олгосон дамжуулан зээлдүүлэх гэрээний хүүгийн орлогыг 2023-2024 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлж эргэн төлүүлэхээр хянаж баталсан байна. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн гэрээний дагуу “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуй хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл” МОН-1907-ын хүрээнд олгосон гэрээ¹-ний дагуу төлөх хүүгийн төлбөр байна.

Дорнод аймгийн Нийгмийн даатгалын газрын тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, ажилгүйдэл гэсэн 4 сангийн данс арилжааны банканд байршдаг бөгөөд аудит хамрах хугацаанд 2023 онд 56.2 сая төгрөг, 2024 онд 79.2 сая төгрөг нийт 135.5 сая төгрөгийн хүүгийн орлого орсон байна. Хүүгийн орлогыг тэтгэвэр, тэтгэмжийн эх үүсвэрт оруулан тооцсон байна. Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 Нийгмийн даатгалын сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 11.1.4 “сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсны орлого” гэсэн заалттай нийцсэн байна.

Сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн хүүгийн орлогыг тухайн жилд зээлдэгч нарын зээлийн гэрээний дагуу төлөх үндсэн зээл, хүүгийн хэмжээгээр, сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн төлөвлөж, сумдын ИТХ-аар баталсан байна. Энэ нь Хоршоо хөгжүүлэх сангийн “Хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.1.3 , 2.1.4 -т заасантай нийцэж байна.

¹ Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 10 дугаар сарын 31-ний өдөр баталсан Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны зээлийн төслийг хэрэгжүүлэх гэрээ

А.1.2 Торгуулийн орлогыг төлөвлөх бодит хэрэгцээ шаардлага байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: “23.7.2 орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, **торгуулийн** орлого,” гэж заасан. Торгуулийн орлогыг аймгийн ТЭЗ нь Төсвийн тухай хуульд зааснаар дараах байдлаар төлөвлөсөн байна.

Торгуулийн орлогыг Сангийн яамнаас хянаж ирүүлсэн төлөвлөгөөний дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоолоор 2023 онд 1,132.0 сая, 2024 онд 1,382.0 сая төгрөгөөр төлөвлөж тус тус баталсан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан зөрчлүүдэд оногдуулсан торгох шийтгэлээс төсөвт төвлөрсөн орлогын 40-өөс доошгүй хувийг дараагийн төсвийн жилд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар, Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4-т “нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль”-ийг авто замын сангийн эх үүсвэр болгож, зарцуулахаар заасан байна.


Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д “*хяналт шалгалтын байгууллага улсын болон орон нутгийн төсөвт орлого оруулах үүрэг хүлээхгүй*” гэж заасан тул зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтантай байгууллагууд торгуулийн орлогыг төлөвлөдөггүй байна.

А.2 Хүү, торгуулийн орлогыг төлөвлөхдөө орлого бүрдүүлдэг байгууллагуудын зөрчлийн тоо хэмжээ, хэрэгжилт зэрэг суурь судалгаа гаргаагүй, давсан болон дутсан нөхцөл байдлыг үнэлж дүгнээгүй байна.

А.2.1 Торгуулийн орлогын биелэлт 2023 онд 92.6 хувь, 2024 онд 144 хувийн биелэлттэй байна.

Дорнод аймгийн торгуулийн орлогын төлөвлөгөө 2023 онд 92.6 хувь, 2024 онд 144.08 хувьтай биелсэн байна.

Дүрслэл 1 /Торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл/



Аймгийн торгуулийн орлогыг бүрдүүлэгч байгууллагын 2023, 2024 оны төлөвлөгөө дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Төсөвт байгууллагын орлогын төлөвлөгөө /сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	2023 он	2024 он
		Төлөвлөгөө	Төлөвлөгөө
1	Санхүүгийн хяналт дотоод аудит	10.0	10.0
2	Цагдаагийн газар	1,000.0	1,000.0
3	Дорнод аймаг дахь ШШГГ	100.0	100.0
4	Татварын газар	22.0	272.0
	дүн	1,132.0	1,382.0

Эх сурвалж: Санхүү, төрийн сангийн хэлтсийн судалгаа

Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэс торгуулийн орлого төвлөрүүлэх байгууллагаар ангилан төвлөсөн боловч иргэдээс ямар зөрчлийн торгуулийг төлж байгаа нь тодорхой бус, гүйлгээний утга дээр овог нэр, регистрийн дугаар бичиж төлдөг зэрэг шалтгааны улмаас торгуулийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг байгууллага бүрээр гаргаагүй байна.

Сумдын торгуулийн орлогын төлөвлөгөө 2024 онд Булган, Гурванзагал, Матад, Сэргэлэн, Цагаан-Овоо, Чойбалсан, Чулуунхороот, Хэрлэн 150.0-936.5 хувиар давж биелсэн бол Дашбалбар, Хөлөнбуйр сумын орлого 56.9-73.3 хувиар дутуу биелсэн байна. Энэ нь торгуулийн орлогыг урьдчилан тооцох боломжгүй, тохиолдлын шинж чанартай байгаагаас шалтгаалсан байна.

А.2.2 Торгуулийн орлогыг төлөвлөхдөө орлого бүрдүүлдэг байгууллагуудын зөрчлийн тоо хэмжээ, хэрэгжилт зэрэг суурь судалгаагүй зөвхөн өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь торгуулийн орлогыг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд тулгуурлан 2023 онд 1,132.0 сая төгрөг 2024 онд 1,382.0 сая төгрөгөөр төлөвлөж, Сангийн яам жил бүр хянасан байна.

Торгуулийн орлогыг төлөвлөхдөө орлого бүрдүүлдэг байгууллагуудын зөрчлийн тоо хэмжээ, хэрэгжилт зэрэг суурь судалгаа гарган дүн шинжилгээг хийгээгүй, зөвхөн орлогын гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөсөн байна.

Дорнод аймгийн сумдын торгуулийн орлогын төлөвлөлт харилцан адилгүй байна.

Хүснэгт 2. Сумдын торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

д/д	Сумдын нэрс	2023 он		Биелэлт хувь	2024 он		Биелэлт хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Баяндун	3.0	3.0	101.1	5.0	5.0	100.8
2	Баянтүмэн	3.0	2.5	83.3	27.5	29.6	107.6
3	Баян-Уул	5.0	9.0	180.1	11.0	12.8	116.3

4	Булган	26.0	29.2	112.4	20.0	46.2	231.2
5	Гурванзагал	1.5	-	-	1.0	9.4	936.5
6	Дашбалбар	1.0	4.6	455.4	7.0	4.0	56.9
7	Матад	5.0	7.2	144.3	9.0	20.4	227.0
8	Сэргэлэн	1.9	1.9	101.8	1.0	3.1	305.3
9	Халхгол	5.5	5.8	105.3	-	8.4	-
10	Хөлөнбуйр	60.0	103.6	172.7	160.0	118.3	73.9
11	Цагаан-Овоо	1.5	2.0	132.3	1.5	2.9	194.2
12	Чойбалсан	0.5	1.8	363.6	0.5	2.3	465.3
13	Чулуунхороот	1.0	2.5	248.7	1.0	3.2	323.8
14	Хэрлэн	420.0	546.0	130.0	300.0	466.0	155.3
Дүн		534.9	719.2	134.4	544.5	731.7	134.4

Эх сурвалж: /аймгийн ТЕЗ нэгтгэсэн тайлан/

Булган, Сэргэлэн, Чойбалсан, Хэрлэн сумд өмнөх жилүүдэд торгуулийн орлогыг 112.4-248.7 хувиар биелүүлсэн байхад 2024 оны торгуулийн орлогын төлөвлөгөөг өмнөх жилийн гүйцэтгэлээс бууруулан, Баянтүмэн сумын өмнөх жилийн торгуулийн орлогын төлөвлөгөө биелээгүй байхад 2024 онд нэмэгдүүлэн, Цагаан-Овоо, Чойбалсан, Чулуунхороот сумд сүүлийн 2 жилийн торгуулийн орлогын төлөвлөгөөг ижил дүнгээр баталсан байна. Сумдын торгуулийн орлогыг өсгөж, бууруулж төлөвлөсөн тодорхой судалгаа, тооцоо байхгүй байна.

Аймгийн Засаг даргад торгуулийн орлого бүрдүүлдэг байгууллагуудын зөрчлийн тоо хэмжээ, хэрэгжилт зэрэг суурь судалгаа гарган төлөвлөлтөд ашиглах зөвлөмж өгөв.

А.2.3 Хүүгийн орлогыг ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг харгалзан тооцож төлөвлөөгүй байна.

Хүүгийн орлогыг ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарахгүйгээр зээлийн гэрээнд заасан хүүгийн хувь хэмжээг үндэслэн эргэн төлөлтийн орлоготой уялдуулан төлөвлөж байна.

Сумдын Хоршоо хөгжүүлэх сангаас олгогдож буй хөнгөлөлтэй зээлийн хүүгийн орлогыг төлөвлөхдөө тухайн сангийн өмнөх жилд олгосон зээлийн хүүгийн орлого, тайлант онд олгогдох зээлийн хүүгийн орлого зэргийг үндэслэн тооцож байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах санал. Сангийн яаманд: Хүүгийн орлогыг ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг харгалзан тооцож төлөвлөх эрх зүйн баримт, жишиг тооцоолол зэргийг боловсруулж, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах.

А.2.4 Торгуулийн орлогоос авто замын санд зарцуулах зардлыг хууль, тогтоомжийн дагуу тооцоолоогүй байна.

Орон нутгийн төсөвт торгуулийн орлого төвлөрүүлдэг аймгийн төсвийн байгууллагуудын болон 14 сумын нийт 34 данс байна. Эдгээр дансанд төвлөрсөн

торгуулийн орлогыг төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд тусгаж, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэн тайлагнаж байна.

Хүү, торгуулийн орлого нь орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлдэг орлогын нэг төрөл бөгөөд эдгээр орлогыг хуваарилах чиг үүрэг нь аймгийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагч, сумдын хувьд сумын Засаг дарга байна.

Торгуулийн орлогыг дараах хууль эрх зүйн хүрээнд хуваарилахаар хуульчилсан байна. Үүнд: Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаанд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1²-т заасны дагуу, Аймгийн авто замын сангийн үйл ажиллагаанд “Авто замын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4³-д заасны тус тус зарцуулах заалт бүхий зохицуулалт айна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд торгуулийн орлогоос дараах байдлаар хөрөнгө төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. ГХУСАЗСЗ-д төлөвлөсөн хөрөнгө /сая төгрөгөөр/

д/д	Нэрс	2023 он	2024 он
		Төлөвлөгөө	Төлөвлөгөө
1	Аймаг	267.8	235.4
2	Баянтүмэн	-	5.0
3	Баян-Уул	-	1.5
4	Хөлөнбуйр	18.5	26.5
дүн		286.3	268.4

Эх сурвалж: аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь 2023, 2024 онд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаанд торгуулийн орлогоос санхүүжилт хуваарилж төлөвлөсөн байна. Аймгийн 14 сумаас Баянтүмэн, Баян-Уул, Хөлөнбуйр сумдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд торгуулийн орлогоос хуваарилсан байна. Бусад сумд торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлыг урьдчилан тооцоогүй байна.

Мөн Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4-т “нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль”, Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-ын 2.5.4. нийслэл, орон нутгийн авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийг тухай бүр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд;" гэж заасан.

² торгуулийн орлогын 40-өөс доошгүй хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараа жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ

³ замын сангийн эх үүсвэрт нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль

Цагдаагийн газрын торгуулийн орлогоос орон нутгийн авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийг тусад нь салгахгүйгээр авто замын санд 2023, 2024 онд Цагдаагийн газрын нийт торгуулийн орлогоос 90 хувиар тооцож хуваарилсан байна.

Харин сумдын “Хоршоо хөгжүүлэх сан”-гийн зээлийн хүүгийн орлогыг тухайн сумдын Хоршоо хөгжүүлэх сангаас дараа онд олгох зээлийн эх үүсвэрийн нэг хэсэг болгон төлөвлөж байна.

А.2.5 Хүү, торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан нөхцөл байдлыг үнэлж дүгнээгүй байна.

Төсвийн төсөлд хүү, торгуулийн орлогыг тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэл өмнөх жилийн гүйцэтгэл зэргийг үндэслэн тооцоолж, бэлтгэж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Аймгийн торгуулийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 2023 онд 1,048.8 сая төгрөг буюу 92.6 хувиар, 2024 онд 1,991.1 сая төгрөг буюу 144.0 хувиар давж биелсэн байна. Хүү, торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан нөхцөл байдлыг үнэлж дүгнээгүй байна. Шалтгаан нь хууль, журам, зааварт хэрхэн үнэлж дүгнэх талаар тусгаагүйтэй холбоотой байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах санал. Сангийн яаманд: Хүү, торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан нөхцөл байдлыг үнэлж дүгнэх талаах журам, зааварт нэмж оруулах.

А.2.6 Орлогын эх үүсвэрийг үнэн зөв тооцоолох эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Орлогын эх үүсвэрийг үнэн зөв тооцоолох эрх зүйн орчин бүрдээгүй байна. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-т “хяналт шалгалтын байгууллага улсын болон орон нутгийн төсөвт орлого оруулах үүрэг хүлээхгүй” гэж заасан тул зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтантай байгууллага нь торгуулийн орлогыг төлөвлөдөггүй байна.

Аудитын судалгаагаар Дорнод аймагт үйл ажиллагаа явуулдаг дараах төсвийн 15 байгууллагын зөрчил хянан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан 2023-2024 онд нийт 310.4 сая төгрөгийн торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 4. Улсын төсөвт орлого төвлөрүүлсэн төсвийн байгууллага /сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	2023 он	2024 он
1	Хилийн цэргийн 0132 дугаар анги	2.10	0.70
2	ТЕГ-ын Дорнод аймаг дахь газар	0.15	1.00
3	Дорнод аймаг дахь Гаалийн газар	2.80	7.80
4	Дорнод НДГазар	9.60	7.10
5	Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар	0.20	3.40
6	Байгаль орчны газар	70.25	106.90

7	Авто тээврийн тав	9.36	-
8	Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	-	2.00
9	ХХААГ, Хяналтын хэлтэс	6.50	6.90
10	Мал эмнэлгийн ерөнхий газар	1.85	4.30
11	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	42.75	9.25
12	Эрүүл мэндийн газар	-	8.30
13	Хилийн цэргийн 0275 дугаар анги	2.20	0.50
14	Хилийн цэргийн 306 дугаар анги	2.00	0.40
15	Хилийн цэргийн 0198 дугаар анги	0.90	1.20
	дүн	150.66	159.75

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2-т “**аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого**” гэж заасан. Төсвийн тухай хуулиар хүү, торгуулийн орлого нь аймгийн төсвийн татварын бус орлогод төвлөрөхөөр заасан байна. Иймд дээрх орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 15 төсвийн байгууллагуудын зөрчил хянан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах саналаар оруулах. Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төсвийн байгууллагуудын зөрчил хянан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны торгуулийн орлогыг тухайн аймгийн төсөвт төвлөрүүлэх эрх зүйн орчныг бий болгох.

А.3 Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлттэй холбоотой эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

А.3.1 Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчинд харилцан уялдаагүй заалтууд байна.

Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг зохицуулж буй эрх зүйн орчин нь Төсвийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авто замын тухай хууль зэрэг үндсэн хуулиудаас гадна холбогдох салбарын бодлого, журам, аргачлалуудыг хамаарч байна. Эдгээр хууль, тогтоомжид үйлдэгдсэн зөрчлийн төрөлд ногдуулах торгуулийн хэмжээ, торгуулийн орлогыг хэрхэн хуваарилахыг заасан байна.

Аудитаар хүү, торгуулийн орлогын эрх зүйн зохицуулалтыг судалж үзэхэд орлого бүрдүүлэлттэй холбоотой зөрчилдсөн заалтууд Авто замын тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль зэрэг 5 хуулиудад байна.

Орлого бүрдүүлэлтийн хууль, тогтоомжид бодит хэрэгцээ шаардлагыг хангаагүй харилцан уялдаагүй заалтуудыг аудитын тайлангийн хавсралтаар оруулж харуулав.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах саналаар оруулах. Хууль, эрх зүйн орчинд харилцан уялдаагүй заалтуудыг засаж сайжруулах.

А.3.2 Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчлагдаагүй байна.

Хүү тооцох аргачлал, хувь хэмжээг холбогдох журмууд болон гэрээний нөхцөлөөр тодорхойлж байна.

Хоршоо хөгжүүлэх сангаас олгож буй хөнгөлөлттэй зээлийн хүүг “Хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.5.1-д зааснаар жилийн 3 хувиар тооцож байна.

Харин Нийгмийн даатгалын сангийн харилцах дансны чөлөөт үлдэгдэлд банкны ерөнхий нөхцөл болон гэрээний үндсэн дээр хүү тооцон орлого олж байна.

Хүү тооцох аргачлал, хувь хэмжээг холбогдох журмууд болон гэрээний нөхцөлөөр тодорхойлж байгаа боловч Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчлагдаагүй байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах санал. Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчлах, энэ нь зээлийн эргэн төлөлтийг нэмэгдүүлж эдийн засагт сайжрах боломжтой.

А.3.3 Хууль тогтоомжид хүү, торгуулийн орлогыг төлөвлөх хуваарилах талаар тодорхой зааж өгөөгүй нь орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Төсвийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журамд хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтэй холоотой тодорхой заалт байхгүй байна. Энэ нь орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлэх, хуваарилах, хяналт тавих аргачлалыг тусгайлан зааж өгөөгүй байна.
- Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 4.2.1⁴, 4.2.2⁵-т гэж заасан боловч татварын бус орлого буюу хүү, торгуулийн орлогын төлөвлөлтийн талаар тодорхой тусгасан зүйл заалт байхгүй байна.
- "Зөрчлийн тухай хууль"-д зааснаар, зөрчил үйлдсэн этгээдэд торгууль ногдуулах, албадлагын арга хэмжээ авах зэрэг зохицуулалтууд байдаг. Гэвч энэ хуульд торгуулийн орлогыг хэрхэн бүрдүүлэх, түүнийг төсөвт хэрхэн төвлөрүүлэх талаар тодорхой заалт дутмаг байна.

Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, бүртгэх бүх шатанд нэгдсэн хяналт хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй бөгөөд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “эрх

⁴ “орон нутгийн төсвийн нийт орлогыг орон нутгийн төсвийн суурь орлого болон хуулиар эрх олгосны дагуу тухайн орон нутагт татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон орлогын нийлбэрээр;”

⁵ “орон нутгийн төсвийн суурь орлогыг тухайн шатны төсөвт орох Улсын Их Хурлаас тогтоосон татварын доод хувь, хэмжээгээр тооцсон татварын болон татварын бус орлогын нийлбэрээр;”

бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна” гэж заасан тул торгууль ногдуулсан эрх бүхий албан тушаалтан хэрэгжилтийг хариуцан хангуулж байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах санал. Төсвийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журамд хүү, торгуулийн орлогыг төлөвлөх хуваарилах талаар тодорхой зохицуулалтыг оруулах.

А.3.4 Зөрчлийн тухай хуулийн 11.9.2 болон 14.7.41, 47 дахь заалтад тусгасан торгуулийн хэмжээ үйлдсэн зөрчилтэй нь нийцэхгүй байна.

Аудитаар нийт 26 торгууль ногдуулах эрх бүхий байгууллагаас 2023-2024 онд нийт 63,437 торгуулийг ногдуулсан байгааг түүвэрлэн судлахад, торгуулийн хэмжээ болон торгосон үндэслэл нь ихэнх тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл, заалттай нийцэж, зөрчлийн шинжид тохирсон байна. Үүнээс дараах асуудалд ногдуулсан торгуулийн хэмжээ нь нийцэхгүй байгаа талаар:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн дараах заалтуудыг зөрчсөн нэр дэвшигч нарт өндөр дүнтэй торгууль ногдуулахаар байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх нийцлийн аудитаар дараах зөрчлийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн. Үүнд:

Сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг төрийн аудитын байгууллагад мэдэгдэж, бүртгүүлээгүй нам, нэр дэвшигч нарт Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21-т *“Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”*, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6-д *“Дараах эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийн шалган шийдвэрлэнэ”* гэж заасны дагуу уг хуулийн 6.12 *“Татварын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн ..., 17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24 дэх хэсэгт заасан зөрчил”-ийг* шалган шийдвэрлэхээр заасны дагуу орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд зардлын дансаа Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт мэдэгдэж, бүртгүүлээгүй 5 нам, 506 нэр дэвшигчдэд хуульд заасан арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийн аймгийн Татварын газарт өгсөн болно.

Сонгуулийн зардлын тайлан ирүүлээгүй нэр дэвшигч нарт Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дүгээр зүйлийн 25. *“Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”*, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар 6-д *“Дараах эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийн шалган шийдвэрлэнэ”* гэж заасны дагуу уг хуулийн 6.22 *“Нягтлан бодох*

бүртгэлийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн ..., 17.1 дүгээр зүйлийн 25, 27 дахь хэсэгт заасан зөрчил"-ийг шалган шийдвэрлэнэ. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 170 дугаар тогтоолоор баталсан "Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн дүрэм"-ийн 2.4-т "Мэргэшсэн нягтлан бодогчийн эрхтэй, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч, нягтлан бодох бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт улсын байцаагчийн эрх олгоно" гэж заасан байна. Зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй 48 нэр дэвшигч нарт хуульд заасан арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийн аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст өгч байсан.

Дээрх зөрчлүүдэд ногдуулах торгуулийн хэмжээ нь нийт 6,040.0 сая төгрөгт хүрч байгаа нь үйлдсэн зөрчлөөсөө хэтэрсэн торгуулийн арга хэмжээ байна гэж үзэж Нийслэл дэх төрийн аудитын газрын нэгдсэн тайланд сонгуулийн данс, тайлангаа ирүүлээгүй тохиолдолд 10.0 сая төгрөгөөр торгууль ногдуулж байгаа нь нэр дэвшигчдэд хүнд тусаж байгаа талаар тусгуулах санал хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Дорнод аймгийн Татварын газраас ЗтХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.19.2.3-т заасан 39 зөрчилд 36.9 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна. Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлд Татварын тухай хууль зөрчсөн тохиолдолд ногдуулах торгуулийг заасан байдаг. Хуулийн 11.19 дүгээр зүйлийн 11.19.2.2.1-2.7 дахь заалтуудад заасан зөрчилд аж ахуйн нэгж нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг буюу 1.5 сая төгрөгөөр торгохоор заасан байна. Үүнд:

- 2.1 хуулиар татвар төлөх, суутгах үүрэг хүлээсэн хүн, хуулийн этгээд татвар төлөгчөөр бүртгүүлэх;
- 2.2 татварын албанд хувийн хэрэг нээлгэх;
- 2.3 татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд татварын албанд тушаах;
- 2.4 орлогоос бусад татвар ногдох зүйлийг өмчлөгч, эсхүл эзэмшигч нь уг зүйлийг өмчилж, эсхүл эзэмшиж эхэлснээс хойш хуулиар тогтоосон хугацаанд татварын албанд мэдэгдэх, хувийн хэрэг нээлгэх, хувийн хэрэгтээ өөрчлөлт хийлгэх;
- 2.5 санхүүгийн тайлан, бүртгэлийг Татварын ерөнхий хуульд заасан журмын дагуу хөтлөх;
- 2.6 Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин, хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, төлбөрийн баримтын цаас, пос терминал машин хэрэглэх;
- 2.7 төлбөрийн баримтыг татварын нэгдсэн системийн санд илгээх үүргээ биелүүлээгүй хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тухайлбал татварын улсын байцаагч нь аж ахуйн нэгж татварын албанд хувийн хэрэг нээлгээгүй байх, хугацаа хоцроож тайлангаа тушаах, хувийн хэрэгтээ өөрчлөлт хийлгээгүй зэрэг дээрх зөрчлүүдэд хуулийн этгээдийг 1.5 сая төгрөгийн торгууль ногдуулж байгаа нь гаргасан зөрчлөөсөө давсан торгууль оногдуулж байна.

Дорнод аймгийн Татварын газрын 2023-224 онуудад ногдуулсан торгуулийг ангилан хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. Татварын газрын ногдуулсан торгууль /сая төгрөг/

д/д	Орлого төвлөрүүлэгч байгууллагын нэр	Торгуулийн ангилал, төрөл	2023 - 2024 он		
			Ногдуулсан	Зөрчлийн тоо	Төвлөрсөн
1	Татварын газар	ТЕХ 42.1, 79.1, 79.4.3	2,164.4	130	1,356.4
2		ЗТХ 11.19 2.3	36.9	39	32.3
3		ЗТХ 11.19 8.1	19.7	262	19.4
4		ЗТХ 11.24 1.1	20	2	20

Эх сурвалж: Аудитын судалгаа

Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 14.7.41-т "Жолооч тээврийн хэрэгслийн холын гэрлийг ойрын гэрэлд шилжүүлээгүй, эсхүл тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл хэрэглэх журам зөрчсөн бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно." гэж заасан нь зам тээврийн осол гарах шалтгаануудыг нэг болох гэрэл шилжүүлэхгүй байх, стандартаас давсан хүчтэй гэрэлтэй хот хоорондын замд явж өөдөөс ирж байгаа авто тээврийн хэрэгслийн үзэгдэх орчныг хязгаарлаж улмаар осол хийх шалтгаан болдог байна. Дээрх торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчил цаашид учруулж болох эрсдэлийн хувьд хэт бага дүн бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.5.1-т "Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтан, шүүхээс оногдуулсан торгох шийтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд биелүүлэх бол шийтгэлийн хэмжээг 50 хувиар хөнгөрүүлнэ." гэсэн заалтын хүрээнд хугацаанд нь торгуулиа төлбөл 10.0 мянган төгрөг төлж байгаа нь дээрх зөрчил арилахгүй, осол аваар гарах шалтгаан болсоор байна.

Зөрчлийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.5.1-т заасан торгуульд хөнгөлөлт үзүүлэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль бүгдэд адил тэгш үйлчлэх зарчим, шударга ёсны зарчимтай нийцэхгүй байна.

1. Үндсэн хуулийн 14.1: Адал тэгш байдлын зарчимд нөлөөлнө.

- Нэг ижил зөрчил үйлдсэн ч, хурдан төлөх мөнгөтэй хүн бага торгууль төлж, мөнгөгүй эсвэл хугацаандаа төлж чадахгүй хүн бүрэн дүнг төлдөг.
- Энэ нь эдийн засгийн боломжийн ялгаанаас шалтгаалан ижил зөрчилд ялгаатай шийтгэл оногдож байгаа хэрэг.

2. Үндсэн хуулийн 16.14: Үйлдэл–хариуцлагын тэнцвэрийн зарчимд сөргөөр нөлөөлнө


- Торгуулийн хэмжээ нь зөрчлийн хор уршиг, буруутай байдлаар биш, харин төлөх хурдтай нь уялдаж өөрчлөгдөж байгаа нь шударга бус.
- Ингэснээр зөрчил үйлдсэн хүмүүсийн хариуцлага жигд биш болно.

3. Шударга ёс ба хууль ёсны зарчимд эргэлзээ төрүүлнэ

- Шийтгэлийн зорилго бол зөвхөн мөнгө хурдан төвлөрүүлэх бус, дахин зөрчил гаргахгүй байх сэдэл өгөх.
- Урамшууллын хөнгөлөлт нь зарим хүнийг “торгууль төлөх нь амархан” гэж ойлгуулж, сэрэмжлүүлэх нөлөөг сулруулдаг.

Дорнод аймагт бүртгэгдсэн зам тээврийн ослын тоо мэдээллийг сүүлийн 5 жилийн байдлаар дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 2



Эх сурвалж: www.1212.mn

Нийслэл дэх төрийн аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах санал. ЗТХ-ийн 3.5.1., 11.19.2.3, 14.7.41, 17.1.21, 17.1.25 дахь заалтууд үйлдсэн зөрчилтэй нь нийцэхгүй байна.

А.3.5 Хуулийн хэрэглээ нь бүх нийтэд харилцан адилгүй үйлчилж байна.

УИХ-аас болон ЗГ-аас аж ахуйн нэгжүүдэд хууль хэрэглээний адил тэгш байдлыг алдагдуулсан тодорхой томоохон аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх хууль, тогтоолыг баталж байна.

Тухайлбал: ЗГ-аас 2023 он 19 дүгээр тогтоолоор 36 аж ахуйн нэгж, байгууллагын 5673 гадаад ажилтныг, 2025 оны 31 дүгээр тогтоолоор 54 аж ахуйн нэгж, байгууллагын 14952 гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн тогтоол, УИХ-аас 2020 онд баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль нь зөвхөн Дархан уул аймагт барих арьс, шир, ноос, ноолуур боловсруулах дэд бүтцийн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийг 2024.01.01-ний өдрийг хүртэл нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн, 2022 онд баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд "24 болон түүнээс дээш суудалтай, 45 болон түүнээс дээш зорчигчийн багтаамжтай, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний зориулалт бүхий шинэ автобусыг

импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн, 2024 онд Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаан буудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлсөн байна.

Хууль тогтоох байгууллагаас томоохон аж ахуйн нэгжүүд рүү чиглэсэн нэг талыг барьсан хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлж байгаа нь нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, гаалийн тариф, татварын тухай хуулийг адил тэгш үйлчлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Нийслэл дэх төрийн аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах санал: Төрөөс ААН-д адил тэгш өрсөлдөх боломжийг үгүйсгэсэн хууль, тогтоомж баталж байгаа талаар оруулах.

Хууль хэрэглээг бүх нийтэд адил тэгш үйлчлүүлэхэд цахимаар худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт дутагдаж байна. Иймд Татварын хууль тогтоомж цахимаар худалдаа эрхлэгч нарт хүрч үйлчлэхгүй байна. Дорнод аймгийн хэмжээнд онлайн худалдаа эрхэлдэг иргэдийн судалгаа, бүртгэл мэдээлэл Татварын газарт байхгүй байна.

ЗтХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.19.2.6-д "Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин, хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, төлбөрийн баримтын цаас, ПОС терминал хэрэглэх;" гэсэн заалт зах дээр лангуу түрээсэлж ажиллуулдаг, ил задгай талбайд худалдаа эрхэлдэг зарим иргэдэд хүрч үйлчлэхгүй байна. Жишээлбэл үйлчилгээний талбай, лангуу түрээсэлж худалдааны бизнес эрхэлдэг хувь хүнд татварын газарт бүртгүүлэх, тайлан гаргах, е-баримт, татвар төлөх гэх мэт шаардлагуудыг тавьж биелүүлээгүй тохиолдолд торгууль ногдуулдаг бол гэрээсээ онлайнаар иргэдээс бараа бүтээгдэхүүний захиалга авч онлайн худалдааны ОУ-ын цахим сайтад захиалгыг оруулж ирсэн барааг хүргэлтээр өгч хүргүүлж ажилладаг хувь хүнд татварын тухай хууль үйлчлэхгүй байна. Иймд лангуу түрээсэлж худалдаа эрхэлдэг хүн, цахим дэлгүүртэй хүн хоёрт татварын хууль тогтоомж адил тэгш үйлчлэхгүй байгааг харуулж байна. Энэ асуудалд Татварын ерөнхий газраас анхаарал хандуулж улсын хэмжээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж үр дүнд хүргэх тухай саналыг Нийслэл дэх төрийн аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулахаар шийдвэрлэлээ.

Авто тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Авто тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх, авто тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, аймаг, нийслэлийн нийтийн зорчигч тээвэр, таксины үйлчилгээг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.3, 5.5, 5.12-т заасан тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд эрхэлнэ." аймгийн төвд өмнө онуудад такси үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байхгүй байсан бөгөөд 2025 оноос такси үйлчилгээ эрхлэгч "Энби ворлд" ХХ-ний эрхэлж буй "Юбикаб" такси үйлчилгээнд Авто тээврийн тухай хууль, Такси үйлчилгээ эрхлэх "Ерөнхий шаардлага" MNS 5122:2013 стандартын шаардлагуудыг хангуулах, цаашид улирал бүр мэдээ мэдээллийг ирүүлэх албан мэдэгдлийг хүргүүлж ажилласан байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлд заасан энгийн зөвшөөрлийн жагсаалтын 10.13-т "нийтийн эзэмшил гудамж, талбайд худалдаа, үйлчилгээ

эрхлэх зорилгоор талбай ашиглах” зөвшөөрлийг тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга олгохоор тусгасан байдаг. Дорнод аймгийн хэмжээнд нийтийн эзэмшлийн талбайд ил задгай худалдаа эрхлэгчдэд зөвшөөрөл олгоогүй байна. Ингэснээр иргэд, аж ахуйн нэгжүүдийг хуульд заасан зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж орлого олох боломжийг боогдуулж, торгууль төлбөрт орох нөхцөлийг бий болгож байна.

А.3.6 Орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2-т “аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого”, 23.9.3-т “сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: хууль тогтоомжийн дагуу сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсөвт орох бусад орлого” гэж заасан. Зөрчлийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.5.1-т “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтан, шүүхээс оногдуулсан торгох шийтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд биелүүлэх бол шийтгэлийн хэмжээг 50 хувиар хөнгөрүүлнэ.” гэсэн заалт 2023 оны нэмэлт өөрчлөлтөөр тусгагдсанаар торгуулийн ач холбогдлыг бууруулж, хөнгөлөлт эдлүүлж зөрчлийг давтан гаргах нөхцөлийг бий болгож байна.

Дорнод аймгийн Цагдаагийн газрын 2024 онд ногдуулсан торгуулийн 23.7 хувь хөнгөлөлт эдэлсэн байна.

Хүснэгт 6 /сая төгрөгөөр/

Торгууль ногдуулсан байгууллагын нэр	Торгуулийн хуудасны тоо	Ногдуулсан торгуулийн дүн	Төвлөрсөн дүн	Хөнгөлөгдсөн дүн
Дорнод аймгийн Цагдаагийн газар	14.2	316.2	241.3	74.9

Эх сурвалж: Аудитын судалгаа

Стандарт хэмжил зүйн сорьцын улсын байцаагч нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд заасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалалд тусгагдаагүй байна. Иймд Стандарт хэмжил зүйн сорьцын улсын байцаагч нь ЗТХ-ийн 7.11 дүгээр зүйлийн 7.11.3-т “Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг тогтоолгох, эсхүл бүртгүүлэх журам зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” заасан зөрчилд торгууль ногдуулах эрхгүй, зөвлөмж өгч ажиллаж байна.

Дээрх хуулийн заалтуудад шинэчлэлт, сайжруулалт хийх шаардлагатай талаар Нийслэл дэх төрийн аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах санал хүргүүлэв.

А.3.7 Хүү, торгуулийн орлого нь иргэний өмчийн халдашгүй байдалд шууд зөрчилдөөгүй бөгөөд хуулийн хүрээнд хязгаарлаж байна.

Хүү, торгуулийн орлого нь иргэний өмчийн халдашгүй байдлын зарчимтай тодорхой хэмжээгээр уялддаг боловч энэ нь шууд зөрчилдөөн биш, харин хууль ёсны үндэслэлтэй, хязгаарлагдмал байдлаар хэрэгждэг зохицуулалт юм.

Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн шалгалтаар тогтоогдсон торгуулийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд шат дараалсан арга хэмжээ авч ажилладаг бөгөөд өмчид нь халдах арга хэмжээ нь хамгийн сүүлийн арга хэмжээ байдаг.

Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 3.4.4-т *"Шүүх, эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгчийн хөрөнгө, цалин хөлс, бусад орлогыг харгалзан торгох шийтгэлийг нэг жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж болно."* гэсэн заалт нь иргэний өмчид шууд халдах эрсдэлийг бууруулж байна.

Тухайлбал Татварын ерөнхий хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-т "татварын алба татварын өрийг хураах үйл ажиллагааг дараах дарааллын дагуу хэрэгжүүлнэ: 1. нэхэмжлэх хүргүүлэх, 2. татварын өрийг үл маргах журмаар гаргуулах, 3. бэлэн мөнгө хураах, 4. хөрөнгө болон авлага битүүмжлэх, 5. битүүмжилсэн хөрөнгийг хураах, 6. битүүмжлэн хураасан хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх, 7. орлогыг хуваарилах" гэж заасан байна. Мөн хамгийн түгээмэл цагдаагийн торгуулийг биелүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт *"... цагдаагийн алба хаагч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг торгох шийтгэлийг биелүүлж дуусах хүртэл хугацаанд хязгаарлана. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийг хуульд заасан журмын дагуу тусгай талбайд хүргэх, эсхүл холбогдох хууль тогтоомжид заасан бусад аргаар хөдөлгөөнийг нь хязгаарлана."* гэж заасан байдаг.

Б.1. УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХЭЭР НОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БИЕЛЭЛТ 61.7 ХУВИЙН БИЕЛЭЛТТЭЙ БАЙНА.

Б.1.1 Хууль, журмын дагуу тогтоосон торгуулийн орлого 61.7 хувийн биелэлттэй байна.

Дорнод аймгийн Улс, орон нутгийн төсөвт торгуулийн орлого төвлөрүүлэгч байгууллагуудаас 2023-2024 онуудад 5,208.8 сая төгрөгийн торгууль тогтоож 3,215.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж 61.7 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Орлого дутуу төвлөрүүлсэн АЗДТГ-ын салбарын хяналт, зохицуулалтын хэлтэс 49.0 сая төгрөг, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 94.2 сая төгрөг, Цагдаагийн газар 1,155.2 сая төгрөг, Татварын газар 694.3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн торгуулийн үлдэгдэлтэй байна.

АЗДТГ-ын салбарын хяналт, зохицуулалтын хэлтэс 49.0 сая төгрөгийн үлдэгдлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 94.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн үлдэгдлийг ЗГ-ын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 6.3.6-д *"санхүүгийн хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх."* гэсэн заалтыг хэрэгжүүлж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллаагүй байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ЗГ-ын 2015 оны 483 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Цагдаагийн газрын 742.8 сая төгрөгийн бэлэн торгууль ногдуулсны 324.1 сая төгрөг нь төвлөрсөн, бэлэн бусаар 1,435.1 сая төгрөгийн торгууль ногдуулсны 698.6 сая төгрөг нь төвлөрсөн буюу нийт 2,177.9 сая төгрөгийн торгуулийн орлогоос 1,155.2 сая төгрөг буюу 53 хувь нь төвлөрөөгүй байна. Цагдаагийн газраас авто замын эргүүл, хяналтыг хэрэгжүүлж ЗтХ-ийн 3.8-р зүйлийн 3.8.4-т заасныг үндэслэн торгуулиа төлөөгүй иргэнийг газар дээр нь торгуулийг нь төлүүлэх, жолоодох эрхийг хасах зэрэг арга хэмжээг авч ажиллаж байгаа ч торгуулийн үлдэгдэл өндөр хэвээр байна.

Дорнод аймгийн татварын газар нь 2023 онд 400.0 сая төгрөгийн торгууль ногдуулснаас 164.3 сая төгрөгийн, 2024 онд 1,841.2 сая төгрөгийн торгууль ногдуулснаас 530.0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн торгуулийн орлогыг тус тус төвлөрүүлээгүй байна. Татварын газраас ТЭХ-ийн 55-р зүйлд заасны дагуу торгуулийн орлогыг төвлөрүүлэх шат дараалсан ажилбар хийж байгаа ч торгуулийн орлого бүрэн төвлөрөөгүй байна.

Аймгийн Цагдаагийн газар, Татварын газарт. Хугацаа хэтэрсэн торгуулийн орлогыг төвлөрүүлэх үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулж ажиллах зөвлөмж өгөв.

Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргаа нь 2023 онд ногдуулсан 10.5 сая төгрөг, 2024 онд ногдуулсан 2.0 сая төгрөг нийт 12.5 сая төгрөгийн торгуулийн орлогыг хүү, торгуулийн дансанд төвлөрүүлэлгүй өөрийн үндсэн данс болох 100070013005 тоот дансаар авч дотоод үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Энэ нь "Зөрчлийн тухай хууль"-ийн 4.3 дугаар зүйл.Хохирол, нөхөн төлбөр гаргуулах гэсний 1-т заасан "Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, зөрчлийн улмаас учирсан хохирол барагдуулах, хор уршгийг арилгах арга хэмжээнд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах **албан шаардлага** хүргүүлэв.

Б.1.2 Торгуулийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан тогтоож байна.

Торгуулийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд ногдуулсан байна. Аудитад хамрагдсан эрх бүхий 26 байгууллагын торгууль ногдуулах эрхтэй 487 албан тушаалтнуудаас түүвэрлэн горим, сорил хэрэгжүүлэхэд зөрчил илрээгүй болно.

Б.1.3 Орлого бүрдүүлэлтийг санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд бүрэн тусгаж тайлагнасан байна.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хүү, торгуулийн орлогыг үнэн зөвөөр тусгаж ажилласан байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүү, торгуулийн орлогын дансны хуулгыг Сангийн яамны сайтаас татан авч төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай тулган үзэхэд зөрчил илрээгүй.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь торгуулийн орлого төвлөрүүлэгч байгууллагуудтай тулган баталгаажуулалт хийдэггүй байна.

Б.1.4. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт нь төсвийн орлогын бусад эх үүсвэрт нөлөөлөхгүйц хувийг эзлэхгүй байна.

Дорнод аймгийн 2023 оны ерөнхий орлого 82,963.5 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 1,231.0 сая төгрөгөөр тасарсан бол, 2024 оны орлого 97,316.2 сая төгрөгт хүрч орлого төлөвлөснөөс 3,638.0 сая төгрөгөөр давж биелсэн байна. Нийт орлогын 2023 онд 2.1 хувийг, 2024 онд 2.8 хувийг хүү, торгуулийн орлого эзэлж байна.

Б.2. Торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023 онд 63.3 хувиар, 2024 онд 66.7 хувиар тус тус дутуу хөрөнгө хуваарилсан байна.

Б.2.1 Төсвийг хуваарилах эрх бүхий байгууллага бүрэн эрхийн хүрээнд төсвийг баталж байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлд Иргэдийн төлөөлөгчдийн бүрэн эрхийг заасан байдаг. Уг хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9-д “Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах,” гэсэн бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн төсвийг баталж байна. Дорнод аймгийн ИТХ-аас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023 онд 282.1 сая төгрөг, 2024 онд 235.4 сая төгрөгийг хуваарилж баталсан байна.

Б.2.2 Торгуулийн орлогыг хуваарилахдаа баталсан хууль тогтоомжид нийцүүлж хуваарилахгүй байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5.2, 5.3 дугаар зүйл, ... 15.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.”, Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 2.5.4-т “нийслэл, орон нутгийн авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийг тухай бүр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд,” торгуулийн орлогыг хуваарилах талаар тодорхойлсон.

Дорнод аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд хуульд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.1-д заасан хэмжээ болох 40 хувьд хүрэхгүй дүнгээр хуваарилж байна.

Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4-т “нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль,” гэж авто замын сангийн эх үүсвэрийг заасан байдаг. Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран

зарцуулах журам"-ын 2.5.4-т "нийслэл, орон нутгийн авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийг тухай бүр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллахгүй, аймгийн хүү, торгуулийн орлогын дансанд төвлөрүүлж байна.

Энэ нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.1-д гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтийг хүү, торгуулийн орлогын 40 хувиар тогтоосон бөгөөд уг ажлын санхүүжилтийн дийлэнх хувийг цагдаагийн байгууллага авч зарцуулдагтай холбоотой байна. Дээрх асуудлыг Нийслэл дэх төрийн аудитын газрын нэгдсэн тайланд замын цагдаагийн торгуулийн орлого өөр дансаар дамжихгүйгээр шууд авто замын сангийн дансанд төвлөрдөг байх **санал хүргүүлэхээр шийдвэрлэв**.

Б.2.3 Торгуулийн орлогыг зориулалтын дагуу хуваарилсан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-т "... төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доогүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ." гэж заасан.

Дорнод аймгийн хүү, торгуулийн орлогын дансанд 2022 онд 1,921.7 сая төгрөг, 2023 онд 1,767.9 сая төгрөг, 2024 онд 2,722.8 сая төгрөг төвлөрсөн байна. Аймгийн ИТХ нь 2023 оны төсөвт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 282.1 сая төгрөг, 2024 онд 235.4 сая төгрөгийг тус тус баталсан байна. Энэ нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.1-д заасан дүнгээс 2023 онд 63.3 хувиар, 2024 онд 66.7 хувиар тус тус дутуу хуваарилж баталсан байна.

Хүснэгт 7. Аймгийн торгуулийн орлогын гүйцэтгэлийн судалгаа /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	
		2023 он	2024 он
1	Өмнөх оны торгуулийн орлогын гүйцэтгэл	1,921.9	1,767.9
2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулах 40 хувь	768.8	707.2
3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд батлагдсан төсөв	282.1	235.4
5	Зөрүү хувиар	63.3	66.7

Эх сурвалж: Аудитын судалгаа

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах салбар зөвлөл нь 2023 онд батлагдсан 282.1 сая төгрөгийн 67.4 сая төгрөг буюу 23.9 хувийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн байна. Цагдаагийн газар нь уг санхүүжилтийг дүрс бичлэгийн техник хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд зарцуулаагүй нь орон нутгийн төсвөөс теле хяналтын төв байгуулж үе шаттайгаар аймгийн төвийг бүрэн камержуулах ажил хийгдэж байгаатай холбоотой байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-т “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Салбар зөвлөл, гэмт хэргийн нөхцөл байдал, цаашидын төлөвийг харгалзан хуваарилж, зарцуулна” гэж заасан. Дорнод аймгийн ГХУСАЗСЗ-с 2023 онд 16.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хуваарилж олгосон бол 2024 онд төсөв хуваарилаагүй байна.

Б.2.4. Орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг харгалзан үздэггүй байна.

Торгууль ногдуулж орлого төвлөрүүлэх эрх бүхий байгууллагууд, албан тушаалтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлтийг түүвэрлэн горим, сорил хэрэгжүүлж ажиллахад торгуулийн орлогын хэмжээгээр гүйцэтгэлийн тайланг үнэлэх үзүүлэлтэд хамаарахгүй байна. Энэ нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д “Хяналт шалгалтын байгууллага улсын болон орон нутгийн төсөвт орлого оруулах үүрэг хүлээхгүй” гэж заасан тул торгууль ногдуулах эрх бүхий улсын байцаагч нарт торгуулийн орлогын төлөвлөгөө баталдаггүй байна. Иймд улсын хяналтын байцаагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэхдээ орлого төвлөрүүлсэн хэмжээ, биелэлтийн хувиар ажлын үзүүлэлтийг үнэлдэггүй байна.

В.1 ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ АВТО ЗАМЫН САН, ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛД ЗАРЦУУЛСАН БАЙНА.

В.1.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023-2024 онд 517.5 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан ч гэмт хэрэг гаралтын тоо өссөн дүнтэй байна.

Торгуулийн орлогын 40 хувиас доошгүй дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулахаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан. Мөн авто зам дээр гаргасан хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасанд ногдуулсан торгуулийг авто замын санд төвлөрүүлэхээр Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх захиран зарцуулах журамд заасан байдаг. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл зарцуулалтыг зориулалтын дагуу зарцуулж ажилласан байна.

Торгуулийн орлогоос гэмт хэргээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд аймгийн хэмжээнд 2023 онд 282.1 сая төгрөг, 2024 онд 235.4 сая төгрөгийг хуваарилан баталсан байна.



Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хүрэх үр дүнг тодорхой хэмжиж болохуйц тоо, хувиар илэрхийлээгүй, гүйцэтгэлийн тайланд арга хэмжээ бүрээр үнэлж ажилладаггүй байна. Иймд уг зөрчлийг арилгах зөвлөмжийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах салбар зөвлөлд хүргүүлэхээр шийдвэрлэв.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа аймгийн Цагдаагийн газрын өмнөх оны

бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн гаралт, түүнд хийсэн дүн шинжилгээ, анхаарах асуудлуудын талаарх танилцуулгад дурдсан тухайлбал 2023 онд бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 40%, 2024 онд 23.8%-ийн өсөлт үзүүлсэн байхад уг гэмт хэргийг бууруулахад зориулагдсан хөтөлбөр арга хэмжээг төлөвлөж тусгаагүй, бусад арга хэмжээг үр дүнтэй төлөвлөхгүй, хэт жижиглэж олон төрлийн арга хэмжээ төлөвлөж зохион байгуулснаар гэмт хэргийн гаралт цаашид өсөх хандлагатай болсон байна.

Дорнод аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик тоон үзүүлэлтийг сүүлийн 5 жилээр авч харьцуулалт хийж дүрслэлээр харуулбал.

Дүрслэл 3 “Дорнод аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослын тоон статистик”



Эх сурвалж: www.1212.mn/

Дээрх үр дүнгээс харахад Зам тээврийн осол 2020-2023 онд буурч эерэг өөрчлөлт гарч байсан нь ковид цар тахлын хөл хорио нөлөөлсөн байна. Гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослын тоо сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай харагдаж байна. Энэ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан зардал нь зарим төрлийн гэмт хэрэгт богино хугацаанд тодорхой эерэг нөлөө үзүүлсэн боловч бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо тогтмол өссөн нь зардлын хуваарилалт, зориулалт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Иймд хүү, торгуулийн орлогын эх үүсвэрийг оновчтой, зориулалтын дагуу хуваарилж, гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, үнэлгээ хийснээр зардлын үр ашгийг бий болгох боломжтой байна.

Дорнод аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлаас төсвийн байгууллагуудад 2023 онд 85.0 сая төгрөг буюу 31.7 хувь, 2024 онд 121.2 сая төгрөг буюу батлагдсан төсвийн 51.5 хувийг тус тус олгосныг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт 8. Төрийн байгууллагуудад олгосон санхүүжилт /сая төгрөг/

№	Төрийн байгууллага	2023 он	2024 он	Дүн
1	Цагдаагийн газар	67.46	83.22	150.68
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	-	4.00	4.00
3	Прокурорын газар	4.00	19.00	23.00
4	Тагнуулын газар	-	1.00	1.00
5	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	3.57	10.00	13.57
6	Боловсрол шинжлэх ухааны газар	2.00	3.00	5.00
7	Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар	1.00	1.00	2.00
8	Хилийн цэргийн 0132 дугаар анги	7.0	-	7.00
Нийт дүн		85.02	121.22	206.24

Эх сурвалж: Аудитын судалгаа

Төсвийн байгууллагуудад санхүүжилт олгож гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлж байгаа ч тэдгээрийн ажлын хүрэх түвшнийг тодорхойлоогүйгээс үр дүнг үнэлж ажиллаагүй байна.

Дорнод аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон Прокурорын газар нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 2023-2024 онд 44.8 сая төгрөгөөр орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг нийлүүлж ажиллаж байна. Энэ нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т "Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр үнэ төлбөргүйгээр яаралтай нийтэлж, нэвтрүүлнэ." гэсэн заалтыг хэрэгжээгүй нь хуулийн 32.3-т "Энэ хуулийн 32.2-т заасан хойшлуулшгүй мэдээллийг үнэ төлбөргүй яаралтай нийтэлж, нэвтрүүлэх журмыг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална." гэж заасан журам батлагдаагүйтэй холбоотой байна. Энэ асуудлын Нийслэл дэх төрийн аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах **санал хүргүүлэхээр шийдвэрлэв.**

Дорнод аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2023 оны 5 дугаар "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэн, хуулийн этгээдийг урамшуулах тухай" тогтоолоор сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүн байгууллагын албан хаагч нарт 4.0 сая төгрөгийн урамшуулал олгосон нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны А/183, А/112 дугаар тушаалаар батлагдсан "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах журам"-ын 2.2-т "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүнийг шалгаруулахад дараах шаардлага тавигдана." гэсний 2.2.1-т "нутгийн

захиргааны болон хууль сахиулах байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж байгаа ажил, арга хэмжээг дэмжиж, сайн дураар оролцсон,” гэсэн шаардлагын хангасан иргэн, хуулийн этгээдийг урамшуулж ажиллах Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд албан **шаардлага хүргүүлэв.**

В.1.2 Хүү, торгуулийн орлогыг эдийн засгийн ангиллаар зарцуулсан байна.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаанд аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 13/11 дүгээр тогтоолоор 282.1 сая төгрөг, 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 19/11 дүгээр тогтоолоор 235.4 сая төгрөгийг тус тус баталж, тус хөрөнгийг хөтөлбөр 70106, арга хэмжээ 82201, зардлын эдийн засгийн 210901-т хамруулан төрийн сангийн 100070051000 Засаг дарга тоот дансаар дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

В.1.3 Торгуулийн орлогоор санхүүжүүлсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, сумдад тэгш хүртээмжтэй хүргээгүй байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтийг хамруулах болон олон нийтэд мэдээлэх талаар дараах заалтууд тусгагдсан байна. Үүнд:

- 1.1. Энэ хуулийн зорилт нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалт, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог тодорхойлох замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын эрх зүйн үндсийг тогтооход оршино.
- 9.2.6. Энэ хуулийн 12.1.5, 12.1.6-д заасан хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тогтмол хяналт, шалгалт хийх, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэх;
- 10.2.3. Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, зан үйл, дадлын талаар олон нийтэд тогтмол мэдээлэх;
- 10.2.7. Гэмт хэрэг, зөрчлийн нийгмийн хор аюулыг олон нийтэд таниулах ажлыг тасралтгүй явуулах, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх.
- 16.1.3. Тухайн нутаг дэвсгэрийн төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага, олон нийтийн оролцоотойгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг хангах;

2023 онд аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс үндсэн 4 чиглэлийн хүрээнд 12 төрөлд 53 ажил төлөвлөж, гүйцэтгэлийн биелэлтийг 94 хувьтай дүгнэсэн байна. Мөн 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 3 арга хэмжээ зохион байгуулагдаагүй байна.

Үүнд:

1. Сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл, эмийн хууль бус эргэлтэд хяналт тавих, мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, гарын авлага тараах.
2. Аймгийн хэмжээнд насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Анхаарч хамгаалъя” аян зохион байгуулах.
3. Хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрийн иргэдэд хууль тогтоомжийн сургалт, нөлөөллийн арга хэмжээ болон хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх, туслах хүчний зөвлөгөөнийг зохион байгуулах.

ГХУСАЗСЗ нь 2024 онд давхардсан тоогоор 8628 иргэн, 5731 сурагч, 558 эцэг эх асран хамгаалагч нарт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг хүргэсэн байна.

2024 онд аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 19 байгууллага, 14 сумын салбар зөвлөл хамтран 4 үндсэн чиглэлийн хүрээнд 40 ажлыг төлөвлөн хэрэгжүүлж гүйцэтгэлийг 96 хувьтай тайлагнасан бөгөөд ГХУСАЗСЗ нь 2023 онд 282.1 сая төгрөг, 2024 онд 235.4 сая төгрөгийн санхүүжилт батлуулж гүйцэтгэлээр бүрэн зарцуулсан байна.

Салбар зөвлөлийн гишүүд төлөвлөгөөнд тусгагдсан хариуцсан ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулахаар удирдамжтай ч зөвхөн Хэрлэн сумын хэмжээнд хэрэгжүүлж бусад сумд орхигдож байна.

Батлагдсан арга хэмжээнүүдийг оны эхнээс шат дараатай хэрэгжүүлээгүй, оны сүүл рүү бөөнд нь зохион байгуулсан нь гэмт хэргийн гаралт багасахад үр нөлөө үзүүлээгүй байна.

Дорнод аймгийн хэмжээнд гэмт хэргийн гаралт сүүлийн 3 жилд 30 хувиар нэмэгдсэн нь ГХУСАЗСЗ-өөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь иргэд, олон нийтэд хүртээмж муутай үр нөлөө хангалтгүй байна.

Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2023 онд 979.9 сая төгрөгийн, 2024 онд 355.0 сая төгрөгийн нийт 14 төсөл, арга хэмжээний хүрээнд гэрлэн гарц, таксины зогсоол зэргийг шинээр нэмэгдүүлж, Булган, Хөлөнбуйр, Баян-Уул чиглэлийн авто замын арчлалт хамгаалалт сайжирч, нийтийн эзэмшлийн зам талбай нэмэгдсэнээр олон нийт үр ашгийг нь хүртэж байна.

ГХУСАЗСЗ-д гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, сумдад тэгш хүртээмжтэй, иргэд, олон нийтэд үр нөлөө үзүүлэхээр зохион байгуулах зөвлөмж өгөв.

В.1.4 ГХУСАЗСЗ-ийн хэрэгжүүлж буй ажил нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлж чадахгүй байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөний талаар дараах заалтууд тусгагдсан байна. Үүнд:

3.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц мөн.

15.1.8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа арга хэмжээний үр нөлөөг тогтмол судлах, үнэлэх;


18.2.7. Зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа арга хэмжээний үр нөлөөг тогтмол судлах, үнэлэх;

22.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэгч байгууллага гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын судалгааг хоёр жил тутам гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг гурван жил тутам улсын хэмжээнд, эсхүл тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд, эсхүл тодорхой гэмт хэрэг, зөрчлийн төрлөөр олон нийтийн дунд зохион байгуулна.

22.2. Энэ хуулийн 22.1-д заасан судалгаа нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх байгууллага, тэдгээрийн албан ёсны тоо мэдээнээс хараат бус байх бөгөөд гэмт хэрэг, зөрчлийн бодит нөхцөл байдлыг тогтоох, гэмт хэрэг, зөрчлийн нийгэмд үзүүлж байгаа нөлөөлөл, хор уршгийг тогтоох зорилготой байна.

Жил ирэх тусам гэмт хэргийн гаралт өссөн үзүүлэлттэй байна. Мөн гэмт хэргийн илрүүлэлт нь дунджаар 65% байна. Тайлант хугацаанд Дорнод аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг дараах графикаар харуулав.

Дүрслэл 4.



Эх сурвалж: www.1212.mn/

Сүүлийн 3 жилд гэмт хэргийн гаралт 30 хувиар өссөн байна. Мөн 8,391.1 сая төгрөгийн хохирол учруулсан байна. ГХУСАЗСЗ-ийн хэрэгжүүлж буй арга хэмжээ нь гэмт хэргийн гаралт, зөрчлийн тоо, нийгэм, эдийн засагт учруулж буй хохирлыг бууруулахад нөлөө үзүүлж чадахгүй байна.

В.2 Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг олон нийтэд шилэн дансны цахим хуудсаар мэдээлж ажилласан байна.

В.2.1 Шилэн дансны цахим хуудсанд хүү, торгуулийн орлогыг 2024 оноос эхлэн зөв дүнгээр мэдээлсэн байна.

Шилэн дансны цахим хуудсанд 2023, 2024 онуудын хүү, торгуулийн орлогын мэдээллийг сар бүрийн 08-ны өдрийн дотор мэдээлдэг "Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)" хэсгийн 12003 торгуулийн орлого кодоор бүртгэсэн бол ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зарцуулалтыг "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)" хэсгийн 210901 /бараа үйлчилгээний бусад зардалд/ бүртгэсэн байна.

Дорнод аймгийн хэмжээнд хүү торгуулийн орлогыг 2023 онд 1,666.9 сая төгрөгөөр төлөвлөж, 1,767.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байсан бол аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны мэдээлэлд зөвхөн аймгийн /сумдыг хамруулаагүй/ дүнгээр буюу төлөвлөгөөг 1,132.0 сая төгрөг, гүйцэтгэлийг 1,048.8 сая төгрөг гэж зөрүүтэй дүнгээр мэдээлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд хүү торгуулийн орлогыг 1,926.5 сая төгрөгөөр төсөвлөж 2,722.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй орлого бүрдүүлсэн бөгөөд 2024 оноос эхлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны мэдээлэлд торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нийт аймгийн /сумдыг хамруулсан/ дүнгээр зөв мэдээлж эхэлсэн байна.

В.2.2 Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансны цахим хуудсанд мэдээлснээс бусдаар олон нийтэд хүргээгүй байна.

Хүү, торгуулийн орлогын зарцуулалтын талаарх хуулийн заалтууд:

1. Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “төсөв нь улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахдаа ил тод байдлыг хангасан байх”

2. Авто замын тухай хуулийн 24.7, Авто бензин, дизелийн түлшний албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 312 дугаар тогтоолын хавсралт 2 “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 2.5.4-д “Нийслэл, орон нутгийн авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль

тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийг тухай бүр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд төвлөрүүлнэ”

3. ГХЗУСТ хуулийн 46.1-д “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5.2, 5.3 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.5, 5.6, 5.7 дугаар зүйл, 5.8 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг, 5.9 дүгээр зүйл, 5.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.11 дүгээр зүйлийн 1.5 дахь заалт, 4, 6 дахь хэсэг, 5.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.1 дэх заалт, 3 дахь хэсэг, 5.16, 5.18 дугаар зүйл, 6.3 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 4, 5, 11, 12, 13 дахь хэсэг, 6.18 дугаар зүйлийн 4, 7 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 4, 5, 7, 9 дэх хэсэг, 6.21, 6.22 дугаар зүйл, 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 8.8 дугаар зүйл, 10.4, 10.8, 10.26, 10.28 дугаар зүйл, 11.15 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 13.5, 14.4, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 5, 6, 7, 9 дэх хэсэг, 14.7, 15.1 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.6, 15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.18 дугаар зүйл, 15.20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.21 дүгээр зүйл, 15.22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 15.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-с доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.”

ГХУСАЗСЗ нь хагас жил болон жилийн эцсийн тайлангаа ГХУСАЗЗ-д илгээдэг ба Дорнод аймгийн ИТХ-д мөн жилд 2 удаа тайлагнадаг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 2023 онд 267.8 сая төгрөг, 2024 онд 235.4 сая төгрөгийг зориулан баталснаас 8.7 хувийг буюу 44.0 сая төгрөгөөр орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээг олон нийтэд хүргэж ажилласан байна.

Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлж ажилласнаас бусдаар хүү торгуулийн орлогын зарцуулалтын талаарх дүн, тайланг иргэд олон нийтэд хүргэсэн тайлан мэдээ байхгүй байна.

В.2.3 Иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талууд хүү, торгуулийн орлогын зарцуулалттай холбоотой ил тод байдалд үнэлгээ өгч, санал хүргүүлээгүй байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.1-т “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг улсын хэмжээнд Салбар болон Дэд зөвлөл, төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллагын түвшинд гурван жилд нэгээс доошгүй удаа хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлж, үйл ажиллагаанд нь дүгнэлт хийнэ” гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төрийн аудитын байгууллагаас аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлд жил бүр хийдэг санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээс бусад тохиолдолд хүү, торгуулийн орлогын зарцуулалттай холбоотойгоор иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талуудаас албан ёсны үнэлгээ, санал, дүгнэлт ирүүлээгүй байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах санал. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд: ГХЗУСТ хуулийн 19 дүгээр зүйлд заасан “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэх” гэсний дагуу оролцогч талууд торгуулийн орлогын зарцуулалттай холбоотой ил тод байдалд үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулах.

БҮЛЭГ Г. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН НЭГДСЭН БҮРТГЭЛИЙН САН БҮРДЭЭГҮЙ, ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨ СУЛ БАЙГААГААС ОРЛОГО ТӨВЛӨРӨЛТ ДУТУУ, ЗАРЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДЛЫГ НЭГТГЭН ХЯНАХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

Г.1 Хүү, торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан байхгүйгээс шалтгаалан нийт хэдэн торгууль ногдуулж, хэрэгжилтийг бодитой, нэгтгэсэн байдлаар хянах боломжгүй байна.

Г.1.1 Байгууллага хооронд мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй.

“Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 61 дүгээр зүйлийн 61.7-д “Цагдаагийн байгууллага өөрийн өдөр тутмын үйл ажиллагааны шуурхай, үр дүнтэй байдлыг хангах зорилгоор өөрийн дотоод хэрэгцээнд бусад төрлийн мэдээллийн санг байгуулж болно”, “Татварын ерөнхий хууль”-ийн 33 дугаар зүйлийн 33.1-т “Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд дараах мэдээлэл хамаарна” гэсний 33.1.2-т “татвар, алданги, торгуулийн бүртгэл”, “Гаалийн тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.3-т “гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 13.1-д заасан мэдээллийг гаргах зорилгоор гаалийн мэдүүлэгт үндэслэсэн гаалийн мэдээллийн санг бүрдүүлж, хөтөлнө”, “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1-т “Нийгмийн даатгалын байгууллага шимтгэл төлөгч, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авагчийн, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны болон холбогдох бусад мэдээллийг агуулсан мэдээллийн нэгдсэн сантай байна.” гэж заасан байна.

Монгол Улсын хэмжээнд торгуулийн орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлтийн бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан байхгүй бөгөөд байгууллагууд салбарынхаа цахим системийг ашиглаж байна.

- Цагдаагийн газар нь Зөрчлийн хэрэг бүртгэлийн нэгдсэн санд торгуулийн төлбөрийг барагдуулсан эсэх талаар тийм/үгүй гэсэн тэмдэглэл хийж бүртгэдэг. Замын хөдөлгөөний зөрчлийн торгуулийг төлөх боломжийг хангах зорилгоор **e-Mongolia, SmartCar, Гэрэгэ киоск**, банкны интернэт болон мобайл банкны аппликейшн зэрэг төлбөрийн цахим сувгуудыг нэвтрүүлэн ашиглаж байна.
- Татварын газар нь Tais системээр орлогыг бүртгэж, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлагын газар нэгдсэн сан үүсгэдэг. Иргэд,

байгууллага ногдуулсан торгуулийг үүсгэсэн нэхэмжлэхийн дагуу тухай бүр төлөх бүрэн боломжтой.

- Гаалийн газар нь Кайс системээр орлогыг бүртгэж, Гаалийн ерөнхий газарт нэгдсэн сан үүсгэдэг.
- Нийгмийн даатгалын газар SIGOS системд орлогыг бүртгэж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хэмжээнд нэгдсэн сан үүсгэдэг.

Аймгийн СХДАГ гэх мэт зарим эрх бүхий байгууллага нь төлбөрийн актын барагдуулалт, тогтоосон торгуулийн орлогыг төлөгдсөн эсэхийг төрийн сангийн хүү, торгуулийн данснаас нэг бүрчлэн тулгаж шалгадаг.

Цагдаагийн газар нь хүү торгуулийн нэгдсэн судалгаанд 2023, 2024 онд ногдуулсан нийт торгуулийн орлогоос аймгийн /ЦХ-н хүү торгуулийн орлого-100070000985, ЗЦ-н торгуулийн орлого-100070000988/ тоот дансанд төвлөрүүлсэн орлогын мэдээллийг ирүүлсэн бөгөөд бусад сумдын хүү, торгуулийн данс болон Хэрлэн сумын /Чо Татварын торгууль-100071400952/ тоот дансанд төвлөрүүлсэн торгуулийн мэдээллийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэстэй тулган баталгаажуулаагүй.

Мөн аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь торгууль ногдуулсан байгууллага тус бүрээр тулган баталгаажуулалт хийгээгүй.

Торгууль ногдуулсан эрх бүхий 28 байгууллагын торгуулийн орлого нь аймгийн 3 дансанд төвлөрдөг, мөн нутаг дэвсгэрээс шалтгаалж 14 сумын тус бүр 2-3 дансанд холилдож ордог зэргээс шалтгаалан торгуулийн орлого төлөгдсөн эсэхийг шалгахад хүндрэлтэй байгаа нь торгууль төлөгч иргэн, байгууллагыг чирэгдүүлэх, торгуулийн орлого төвлөрүүлэлт зэрэгт сөргөөр нөлөөлж байна.

Торгуулийн орлогын бүртгэлийн нэгдсэн санг нэвтрүүлэх шаардлагатай, ингэснээр дараах эерэг үр дагаврыг бий болгохоор байна. Үүнд:

- Эрх бүхий ажилтнууд зөрчлийн хэрэг, шийдвэрийг цахимаар бүртгэж, зөрчлийн дугаарыг системээс шууд авах.
- Торгуулийн орлого төвлөрүүлэх ажлын процесс багасах.
- Төлбөрийн үйлчилгээ, цахим платформуудтай уялдуулснаа ногдуулсан торгуулийг онлайнаар, хурдан шуурхай барагдуулах, торгуулийн төлөлт нэмэгдэх.
- Хууль тогтоомжийн хэрэгжилт илүү бодитой хангагдаж, үйлчилгээ ил тод, хүртээмжтэй болох нөхцөл бүрдэх.


Аймгийн Засаг даргад торгуулийн орлогын төвлөрүүлэлтийг байгууллага бүртэй тулган баталгаажуулалт хийж байх зөвлөмж өгөв.

Г.1.2 Торгуулийн төлбөрийн систем бүрэн хэрэгжихгүй байна.

Цагдаагийн байгууллага болон татварын газар нь торгуулийн төлбөрийн системийг сайжруулан бүрэн ашиглаж байна.

Цагдаагийн газраас ирсэн судалгаагаар бэлэн ногдуулсан торгуулийн биелэлт дараах үзүүлэлттэй байна.

Дүрслэл 5.



Эх сурвалж: Аудиторын судалгаа

Зөрчлийн тухай хуулийн 2023 оны 12 сарын 07-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр "Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтан, шүүхээс оногдуулсан торгох шийтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд биелүүлэх бол шийтгэлийн хэмжээг 50 хувиар хөнгөрүүлнэ." гэсэн нь торгуулийн төвлөрүүлэлт ногдуулснаас бага байхад нөлөөлсөн байна.

Мөн цагдаагийн газрын бэлэн торгуулийн орлого нь Хэрлэн сумын хүү, торгуулийн 100071400952 тоот данс, Дорнод аймгийн Цагдаагийн газрын хүү, торгуулийн 100070000985 тоот дансаар давхар орсон бөгөөд Цагдаагийн газар нь нийт орсон торгуулийн орлогыг тулган баталгаажуулалт хийгээгүй байна.

Бусад торгууль ноогдуулдаг эрх бүхий байгууллагуудын хувьд төрийн сангийн дансны хуулгаар болон торгууль төлөгч иргэн, хуулийн этгээдийн төлбөрийн баримтыг биетээр авч тулган баталгаажуулалт хийж торгууль төлөгдсөн эсэхийг мэдэж байгаа нь торгууль барагдуулах, хянах, мэдээлэхэд хүндрэл учруулж байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах санал: Сангийн яаманд: Торгуулийн төлбөрийн системийг боловсронгуй болгох.

Г.1.3 Хяналтын систем нь бүрэн хөгжөөгүйгээс орлого бүрдүүлэлтийн үр дүнд нөлөөлж байна.

Цагдаагийн газрын бэлэн торгуулийн орлого нь Хэрлэн сумын хүү, торгуулийн 100071400952 тоот данс болон аймгийн Цагдаагийн газрын хүү, торгуулийн 100070000985 тоот дансаар давхар орсон байна. Торгууль ноогдуулдаг эрх бүхий байгууллагуудын торгуулийн орлого нь нэг дансанд төвлөрдөг бөгөөд аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэс нь байгууллага тус бүрээр тулган баталгаажуулалт хийгээгүй бөөн дүнгээр орлогыг зөвшөөрч тайлагнасан байна.

Цагдаагийн байгууллагын Хэрлэн суманд бэлэн бусаар ногдуулсан торгуулийн орлого нь нэг дансанд төвлөрдөг ч бусад сумын нутаг дэвсгэрт ногдуулсан

торгуулийн орлого нь тухайн сумын торгуулийн орлогын дансанд бэлэн торгуультай хамт төвлөрсөн байна.

Эрх бүхий байгууллагуудын торгуулийн орлогод системтэй хяналт тавих тогтолцоо бүрдээгүй, бие даасан хяналтын систем, үйл ажиллагаа байхгүй эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцаж ажилладаг, зөрчлийн тухай хуулийн дагуу нэг зөрчлийг хянаж шийдвэрлэж дуусгахад 15-20 хуудас материал бүрдүүлдэг зэрэг нь орлогын бүрдүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах санал. Сангийн яаманд: Торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сантай болох торгуулийн орлого нь оногдуулсан байгууллага тус бүрээр харагддаг байхаар системийн сайжруулалт хийх.

Г.2. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГААС ХЯНАЛТ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА.

Г.2.1 Хугацаа хэтэрсэн торгуулийн орлогыг барагдуулахаар зохион байгуулсан ажлын үр дүн хангалтгүй байна.

Аудитын нэгдсэн судалгаагаар аймгийн хэмжээнд 2023 онд 2,020.8 сая төгрөгийн, 2024 онд 3,188.1 сая төгрөгийн торгууль ноогдуулсан байна. Үүнээс хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй торгуулийн мэдээллийг байгууллагаар нь ангилан харуулбал:

Хүснэгт 9. Хугацаа хэтэрсэн торгуулийн дүн /сая төгрөгөөр/

Орлого төвлөрүүлэгч байгууллагын нэр	2023 он			2024 он		
	Ногдуулсан	Үүнээс		Ногдуулсан	Үүнээс	
		Төвлөрсөн	Дутуу		Төвлөрсөн	Дутуу
Хугацаа хэтэрсэн нийт торгуулийн дүн	1,753.8	1,335.5	211.9	2,890.6	976.0	230.9
Дорнод аймгийн ЗДТГ, Салбарын хяналт зохицуулалтын хэлтэс	-	-	-	77.5	28.5	49
Дорнод аймгийн Татварын газар	400.0	235.7	164.3	1841.2	1311.2	530.0
Дорнод аймгийн Цагдаагийн газар	1,292.8	580.3	712.5	885.1	442.4	442.7
Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	61.0	9.2	51.8	86.8	44.4	42.7
Нийт	1,753.8	825.2	928.6	2,890.6	1,826.5	1,064.4

Эх сурвалж: Аудиторын судалгаа

АЗДТГ-ын Салбарын хяналт зохицуулалтын хэлтсээс 2024 онд оногдуулсан нийт 77.5 сая төгрөгийн торгуулиас 49.0 төгрөгийн торгуулийг төсөвт төвлөрүүлээгүй байна. Үүнээс 31.0 сая төгрөгийн торгуулийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлж ажилласан байна.

Дорнод аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас 2023, 2024 онуудад оногдуулсан 147.8 сая төгрөгийн төлбөрийн актаас 94.2 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байна. Тус газар нь газрын даргын "Өр төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулан ирүүлэх тухай" албан бичгийг төлбөрийн актыг бүрэн

төлөөгүй байгууллагуудад хүргүүлэн актын төлбөрийг барагдуулаагүй шалтгаан, барагдуулах төлөвлөгөөг гаргуулан авч ажиллаж байна.

Цагдаагийн газар нь торгуулийн орлогыг төвлөрүүлэхдээ бэлэн торгуулийн орлогыг Дорнод аймгийн /ЦХ-н хүүгийн торгуулийн орлого-100070000985/, /Чо Татварын торгууль-100071400952/ тоот дансанд 2 салгаж, сумдын нутаг дэвсгэрт ногдуулсан бэлэн ба бэлэн бус торгуулийн орлогыг тухайн сумдын 10007..00985 тоот дансанд Бусад торгуулийн орлогын хамт төвлөрүүлж байгаа бөгөөд торгуулийн орлогоос төвлөрөөгүй дүнг аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэстэй тулган баталгаажуулалт хийгээгүй байна.

Татварын газраас “Зөрчлийн тухай хууль”-ийн дагуу шийтгэврийн хуудсаар ногдуулсан 70.9 сая төгрөг нь бүрэн төлөгдсөн бөгөөд “Татварын ерөнхий хууль”-ийн дагуу нөхөн ногдуулалтын актаар тогтоосон торгууль нь бүрэн төвлөрөөгүй байна. Татварын газраас ТЕХ-ийн 55-р зүйлд заасны дагуу торгуулийн орлогыг төвлөрүүлэх ажилбар хийж байгаа ч торгуулийн орлого бүрэн төвлөрөөгүй байна.

Торгуулийн орлого бүрэн төвлөрөөгүй шалтгааныг судлан, нөхөн барагдуулах болон шаардлагатай арга хэмжээг авах талаар дараагийн шатны зохион байгуулалт, хяналтын ажиллагаа хангалтгүй байсан нь орлого дутуу төвлөрөхөд нөлөөлсөн байна.

Цагдаагийн байгууллагаас ногдуулсан торгуулийг биелүүлэх арга хэмжээг авч байгаа ч иргэдийн шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгслийн идэвхгүй ашиглалт, мэдэгдэл хүрдэггүй байдал, төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа, хамтын ажиллагааны сул тал зэргээс шалтгаалан бэлэн бусаар ногдуулсан торгууль бүрэн барагдахгүй байна.

Хуулийн заалт: Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 2-т *Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор сайн дураар биелүүлнэ.* 8-д *“Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 7.7 дугаар зүйлд заасан харьяалах шүүхэд хүсэлт гаргана”,* Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралт “Дотоод аудитын дүрэм”-ийн 6-р зүйл *“Дотоод аудиторовн эрх, үүрэг”* гэсний 6.3.6-д *“санхүүгийн хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх.”* гэж заасан байна.

Г.2.2 ГХУСАЗСЗ нь ажлын тайлангаа ИТХ-д танилцуулснаас бусдаар эрх бүхий байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.8-д “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад Зохицуулах зөвлөл, төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, тухайн шатны

иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон төсвийн тухай хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина” гэж заасан.

Автозамын тухай хуулийн 25.2-т “Нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ” гэсний 25.2.4-т “Нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль;

Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Автозамын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 2.5.4-т “Нийслэл, орон нутгийн авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийг тухай бүр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд; гэж тус тус заасан.

Аудитаар хамрах хугацаанд хүү, торгуулийн орлогоос аймгийн автозамын сангийн дансанд төвлөрүүлэхдээ дээрх хууль, журмыг баримталж ажиллаагүй байна.

ГХУСАЗСЗ нь 2023 оны 07 сарын 03-ны 1/31 дүгээр албан бичгээр 2023 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайланг, 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 1/01 дүгээр албан бичгээр 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг, 2024 оны 07 сарын 01-ний 1/29 дүгээр албан бичгээр 2024 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайланг, 2024 оны 12 сарын 16-ны өдрийн 1/49 дүгээр албан бичгээр 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангуудыг тус тус ГХУСАЗСЗ-д хүргүүлсэн байна.

ГХУСАЗСЗ нь ажлын тайлангаа ГХУСАЗСЗ болон ИТХ-д танилцуулснаас бусдаар торгуулийн орлогын зарцуулалтад төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймгийн ИТХ, Зохицуулах зөвлөлөөс нарийвчилсан хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Г.2.3 Торгууль ногдуулсан 26 байгууллагаас 4 байгууллагын торгууль бүрэн хэрэгжээгүй байна.

Тайлант хугацаанд Дорнод аймгийн хэмжээнд торгууль ногдуулах эрх бүхий 37 байгууллагаас 26 байгууллага нь торгууль ногдуулж ажилласан ба 9 байгууллага ямар нэгэн зөрчлийн торгууль ногдуулаагүй байна. Дээрх 26 байгууллагаас 22 байгууллага нь ногдуулсан орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлж, 4 байгууллагын орлого бүрэн төвлөрөөгүй байгаа нь дотоод хяналтын хэрэгжилт сул, торгуулийн орлогыг төвлөрүүлэх систем хангалттай ажиллахгүй байгаатай холбоотой байна. Үүнд: АЗДТГ-ын Салбарын хяналт зохицуулалтын хэлтэс нь 2023 онд торгууль ногдуулаагүй, харин 2024 онд ногдуулсан нийт 77.5 сая төгрөгийн торгуулиас 49.0 төгрөгийн торгуулийг төсөвт төвлөрүүлээгүй байна. Үүнээс 31.0 сая төгрөгийн торгуулийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлж ажилласан байна.

Дорнод аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас 2023, 2024 онуудад ногдуулсан 147.8 сая төгрөгийн төлбөрийн актаас 94.2 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байна. Тус газар нь газрын даргын “Өр төлбөрийн

үлдэгдлийг баталгаажуулан ирүүлэх тухай" албан бичиг хүргүүлэн актын төлбөрийг барагдуулаагүй шалтгаан, барагдуулах төлөвлөгөөг гаргуулан авч ажиллаж байгаа бөгөөд дараагийн шатны *"хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх"* арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Цагдаагийн газраас бэлэн бусаар буюу ПОС төхөөрөмжөөр 2023 онд 28,515 зөрчилд 779.8 сая төгрөгийн, 2024 онд 30,245 зөрчилд 655.3 сая төгрөгийн торгууль тус тус ногдуулсан байна. Цагдаагийн газраас авто замын эргүүл, хяналтыг хэрэгжүүлж ЗтХ-ийн 3.8.4-т заасныг үндэслэн торгуулиа төлөөгүй иргэнийг газар дээр нь торгуулийг нь төлүүлэх, жолоодох эрхийг хасах зэрэг арга хэмжээг авч ажиллаж байгаа ч торгуулийн үлдэгдэл өндөр хэвээр байна

Татварын газрын торгуулийн орлогын дийлэнх хувийг бүрдүүлдэг Хяналт шалгалтын тасаг нь өөрсдийн ногдуулсан торгуулиа төвлөрүүлэхэд үүрэг хүлээдэггүй, хяналт шалгалт хэрэгжүүлэх болон орлого төвлөрүүлэх чиг үүрэг нь өөр өөр тасагт хуваарилагдан ажиллаж байгаа нь тогтоосон торгуулийн орлого бүрэн төвлөрөхгүй байхад нөлөөлж байна.

Бусад байгууллагад улсын байцаагчийн тогтоосон торгуулийн орлогыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5.1-т заасан *"Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна."* гэсний дагуу эрх бүхий ажилтан нь торгуулийн орлого төвлөрүүлэлтийг хариуцан ажиллаж байгаа бөгөөд дээд шатны удирдах ажилтан болон дээд шатны байгууллагаас хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байна.

Цагдаагийн газраас ногдуулсан нийт торгуулийн орлогын 53 хувь нь төвлөрүүлээгүй байгаа нь торгуулийн орлого төвлөрүүлэлтэд тавих дотоод хяналт сул байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулах санал. Цагдаагийн бэлэн бусаар ногдуулсан торгуулийн орлогыг хянах, төвлөрүүлэх оновчтой арга замыг бий болгох.

Г.2.4 Иргэн, ТББ, ОУБ-аас хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтад хөндлөнгийн хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аудитын явцад авсан нэгдсэн судалгаа болон эрх бүхий байгууллагуудтай уулзсан уулзалтаас иргэн, ТББ, ОУБ зэрэг хөндлөнгийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлсэн тохиолдол байхгүй байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т *"Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг улсын хэмжээнд болон Салбар болон Дэд зөвлөл, төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллагын түвшинд гурван жилд нэгээс доошгүй удаа хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлж, үйл ажиллагаанд нь дүгнэлт хийнэ."* 38 дугаар зүйлийн 38.1-т *"төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог*

хангана”, 38.2.6-т “гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төсвийн зарцуулалтад олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох” гэж тус тус заасан байна.

Аудитын хамрах хугацаанд иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг хөндлөнгийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байгаа нь журамд заасан хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой тусгаагүйтэй холбоотой байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:


МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ДЭРГЭДЭХ ГЭМТ
ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛ

Санхүүчдийн гудамж, 7 дугаар баг,
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4208, Факс: 7058-4208
Цахим шуудан: ith.dornod@gmail.com
Цахим хуудас: dornod.khural.mn

2025.08.18 № 1/25
танай 2025.08.14-ны № 605 -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Тус салбар зөвлөлийн “Хүү торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд өгөх санал байхгүй болно.

НАРИЙН БИЧИЙН
ДАРГА

Ц.ОДЧУЛУУН

0724100017
ТБЛГ ОЧУУ2051 3400816

З.Замтарагч:
Аудитын ажлын баримт
туу хавсаргана.
2025.08.18
2124100088



ДОРНОД АЙМГИЙН
ЦЭРГИЙН ГАВЬЯНЫ ОДОНТ
ЦАГДААГИЙН ГАЗАР

Чойбалсан, Дорнод аймаг, 21075,
Утас: 70194401, 7058102, Факс: (976) 70194401,
Цахим шуудан: dornod@police.gov.mn
Цахим хуудас: www.dornod.police.gov.mn

2025.08.18 № 3912389

танай _____-ны № _____-т

Б.Батмөнх
Аудитын
Төрийн
Харьяа
2025.08.18

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Тус цагдаагийн газраас "Хүү, торгуулийн
орлогын бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд тусгах санал
байхгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ, ДЭД БӨГӨӨД ЭРҮҮГИЙН
ЦАГДААГИЙН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН
ДЭД ХУРАНДАА Д.МӨНХҮҮ

Ж10Г0014 9029443



ДОРНОД АЙМАГ
ТАТВАРЫН ГАЗАР

Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000

E-mail: domod@mta.gov.mn

Вэб сайт: www.domod.mta.mn

Утас: 7058-3038

2025.08.18 № 603

танай 2025.08.14-ны № 605 -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Тус газар нь "Хүү, торгуулийн орлогын
бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн
тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн
төсөлд өгөх санал байхгүй болно.

ДАРГА

С.БЯМБАРАГЧАА



Б.Баттөр:

хуучин тайлан
хавсруулаа.
2025.08.18

2025 он / бланк А5/

2106304192

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

А.1.1 Хүүгийн орлогыг бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлж төлөвлөх эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

А.1.2 Торгуулийн орлогыг төлөвлөх бодит хэрэгцээ шаардлага байна.

А.2.1 Торгуулийн орлогын биелэлт 2023 онд 92.6 хувь, 2024 онд 144 хувийн биелэлттэй байна.

А.2.2 Торгуулийн орлогыг төлөвлөхдөө орлого бүрдүүлдэг байгууллагуудын зөрчлийн тоо хэмжээ, хэрэгжилт зэрэг суурь судалгаагүй зөвхөн өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна.

А.2.3 Хүүгийн орлогыг ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг харгалзан тооцож төлөвлөөгүй байна.

А.2.4 Торгуулийн орлогоос авто замын санд зарцуулах зардлыг хууль, тогтоомжийн дагуу тооцоолоогүй байна.

А.2.5 Хүү, торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан нөхцөл байдлыг үнэлж дүгнээгүй байна.

А.2.6 Орлогын эх үүсвэрийг үнэн зөв тооцоолох эрх зүйн орчин бүрдээгүй байна.

А.3.1 Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчинд харилцан уялдаагүй заалтууд байна.

А.3.2 Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчлагдаагүй байна.

А.3.3 Хууль тогтоомжид хүү, торгуулийн орлогыг төлөвлөх хуваарилах талаар тодорхой зааж өгөөгүй нь орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

А.3.4 Зөрчлийн тухай хуулийн 11.9.2 болон 14.7.41, 47 дахь заалтад тусгасан торгуулийн хэмжээ үйлдсэн зөрчилтэй нь нийцэхгүй байна.

А.3.5 Хуулийн хэрэглээ нь бүх нийтэд харилцан адилгүй үйлчилж байна.

А.3.6 Орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байна.

А.3.7 Хүү, торгуулийн орлого нь иргэний өмчийн халдашгүй байдалд шууд зөрчилдөөгүй бөгөөд хуулийн хүрээнд хязгаарлаж байна.

Б.1.1 Хууль, журмын дагуу тогтоосон торгуулийн орлого 61.7 хувийн биелэлттэй байна.

Б.1.2 Торгуулийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан тогтоож байна.

Б.1.3 Орлого бүрдүүлэлтийг санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд бүрэн тусгаж тайлагнасан байна.

Б.1.4. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт нь төсвийн орлогын бусад эх үүсвэрт нөлөөлөхүйц хувийг эзлэхгүй байна.

Б.2.1 Төсвийг хуваарилах эрх бүхий байгууллага бүрэн эрхийн хүрээнд төсвийг баталж байна.

Б.2.2 Торгуулийн орлогыг хуваарилахдаа баталсан хууль тогтоомжид нийцүүлж хуваарилахгүй байна.

Б.2.3 Торгуулийн орлогыг зориулалтын дагуу хуваарилсан байна.

Б.2.4. Орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээгээр албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг харгалзан үздэггүй байна.

В.1.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023-2024 онд 517.5 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан ч гэмт хэрэг гаралтын тоо өссөн дүнтэй байна.

В.1.2 Хүү, торгуулийн орлогыг эдийн засгийн ангиллаар зарцуулсан байна.

В.1.3 Торгуулийн орлогоор санхүүжүүлсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, сумдад тэгш хүртээмжтэй хүргээгүй байна.

В.1.4 ГХУСАЗСЗ-ийн хэрэгжүүлж буй ажил нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлж чадахгүй байна.

В.2.1 Шилэн дансны цахим хуудсанд хүү, торгуулийн орлогыг 2024 оноос эхлэн зөв дүнгээр мэдээлсэн байна.

В.2.2 Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансны цахим хуудсанд мэдээлснээс бусдаар олон нийтэд хүргээгүй байна.

В.2.3 Иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талууд хүү, торгуулийн орлогын зарцуулалттай холбоотой ил тод байдалд үнэлгээ өгч, санал хүргүүлээгүй байна.

Г.1.1 Байгууллага хооронд мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй.

Г.1.2 Торгуулийн төлбөрийн систем бүрэн хэрэгжихгүй байна.

Г.1.3 Хяналтын систем нь бүрэн хөгжөөгүйгээс орлого бүрдүүлэлтийн үр дүнд нөлөөлж байна.

Г.2.1 Хугацаа хэтэрсэн торгуулийн орлогыг барагдуулахаар зохион байгуулсан ажлын үр дүн хангалтгүй байна.

Г.2.2 ГХУСАЗСЗ нь ажлын тайлангаа ИТХ-д танилцуулснаас бусдаар эрх бүхий байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Г.2.3 Торгууль ногдуулсан 26 байгууллагаас 4 байгууллагын торгууль бүрэн хэрэгжээгүй байна.

Г.2.4 Иргэн, ТББ, ОУБ-аас хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтад хөндлөнгийн хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар нийт 2,918.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 110.7 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 2,808.0 сая төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж өгч, нэгдсэн тайланд тусгуулах 14 саналыг Нийслэл дэх төрийн аудитын газарт хүргүүлээ.

САНАЛ:

Нийслэл дэх төрийн аудитын газарт

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Сангийн яаманд: Хүүгийн орлогыг ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг харгалзан тооцож төлөвлөх.
2. Сангийн яаманд: Хүү, торгуулийн орлого өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан болон дутсан нөхцөл байдлыг үнэлж дүгнэх аргачлал боловсруулах.
3. Хүү, торгуулийн эх үүсвэрийг тодорхой болгох, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төсвийн байгууллагуудын зөрчил хянан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны торгуулийн орлогыг тухайн аймгийн төсөвт төвлөрүүлэх эрх зүйн орчныг бий болгох.
4. Хууль, эрх зүйн орчинд харилцан уялдаагүй заалтуудыг сайжруулах.
5. Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчлах.
6. Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журамд хүү, торгуулийн орлогыг төлөвлөх хуваарилах, бүртгэх талаар тодорхой заалт оруулах.
7. ЗтХ-ийн 3.5.1., 11.19.2.3, 14.7.41, 17.1.21, 17.1.25 дахь заалтууд үйлдсэн зөрчилтэй нь нийцэхгүй байгаа талаар тусгах.
8. Төрөөс ААН-д адил тэгш өрсөлдөх боломжийг үгүйсгэсэн хууль, тогтоомж баталж байгааг анхаарах.
9. Зөрчлийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.5.1-д заасан торгуулийн хөнгөлөлтийн талаарх заалт нь зөрчил үйлдэх давтамж өсөх хандлагатай болж байгааг анхаарч нэгдсэн тайланд тусгах.

10. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т "Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр үнэ төлбөргүйгээр яаралтай нийтэлж, нэвтрүүлнэ." гэсэн заалтыг хэрэгжихгүй байна. Энэ нь хуулийн 32.3-т "Энэ хуулийн 32.2-т заасан хойшлуулшгүй мэдээллийг үнэ төлбөргүй яаралтай нийтэлж, нэвтрүүлэх журмыг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална." гэсэн заалтын дагуу журам батлагдаагүй байна. Журмыг батлуулах,
11. Зөрчил шалган шийдвэр тухай хуулийн 1.8-д заасан харьяалалд сорьцын улсын байцаагчийг оруулах.
12. Хүү, торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сантай болох торгуулийн орлого нь оногдуулсан байгууллага тус бүрээр харагддаг байхаар системийн сайжруулалт хийх.
13. Татварын газрын торгуулийн орлогыг төвлөрүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулах.
14. Цагдаагийн бэлэн бусаар ногдуулсан торгуулийн орлогыг хянах, төвлөрүүлэх оновчтой арга замыг бий болгох.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Дорнод аймгийн ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга Г.Цолмонд:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг хууль тогтоомжид заасан хэмжээгээр төлөвлөж, батлуулах.
2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хүрэх түвшнийг тоон үзүүлэлтээр илэрхийлж ажиллах, өмнөх оноос өссөн гэмт хэргийн гаралтыг бууруулахад арга хэмжээ төлөвлөж ажиллах.
3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, сумдад тэгш хүртээмжтэй хүргэх.

Дорнод аймгийн Засаг дарга Ш.Ёлд:

1. Орлого бүрдүүлдэг байгууллагуудын зөрчлийн тоо хэмжээ, хэрэгжилт зэрэг суурь судалгаа гарган төлөвлөлтөд ашиглах.
2. Торгуулийн орлогын төвлөрүүлэлтийг байгууллага бүртэй тулган баталгаажуулалт хийж байх.

Дорнод аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа П.Мөнхбаярт:

1. Торгуулийн үлдэгдлийг барагдуулах үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах.
2. Торгуулийн орлогын төвлөрүүлэлтийг аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэстэй тулган баталгаажуулж, төвлөрөөгүй орлогын бодит дүнг гаргаж ажиллах.

Дорнод аймгийн Татварын газрын дарга С.Бямбарэгчаад:

1. Торгуулийн үлдэгдлийг барагдуулах үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

АЛБАН ШААРДЛАГА:


ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 08 сарын 21 өдөр
Дугаар 01/221 НТАГ-2025/27-ШТА-ГА АНТ-0309
Чойбалсан хот

Г Зөрчил арилгах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд "Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дорнод аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2023 оны "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэн, хуулийн этгээдийг урамшуулах" тухай 5 дугаар тогтоолоор сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүн байгууллагын албан хаагч нарт нийт 4.0 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны А/183, А/112 дугаар тушаалаар батлагдсан "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах журам"-ын 2.2.1-т "нутгийн захиргааны болон хууль сахиулах байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж байгаа ажил, арга хэмжээг дэмжиж, сайн дураар оролцсон;" гэсэн шаардлагын хангасан иргэн, хуулийн этгээдийг урамшуулж ажиллах заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төсвийг хууль, журмын дагуу зарцуулах, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллахыг Дорнод аймгийн ИТХ-ын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга бөгөөд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Цолмон, нарийн бичгийн дарга Ц.Одчулуун нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР Б.БАТЖАРГАЛ
АУДИТОР М.УХААНБИЛЭГ
С.ТӨМӨРХУЯГ

2125040667



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 08 сарын 21 өдөр

2022 НТАГ-2025/27-ШТА-ГА

АНТ0309

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргаа нь 2023 онд ногдуулсан 10.5 сая төгрөг, 2024 онд ногдуулсан 2.0 сая төгрөг нийт 12.5 сая төгрөгийн торгуулийн орлогыг өөрийн байгууллагын дансанд авч дотоод үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Энэ нь Зөрчлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.1-т “Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, зөрчлийн улмаас учирсан хохирол барагдуулах, хор уршгийг арилгах арга хэмжээнд зарцуулж, үлдсэн хэсгийг **улсын төсөвт** төвлөрүүлнэ.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Торгуулийн орлогыг хуульд заасны дагуу улсын төсөвт төвлөрүүлж ажиллах, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны дарга Х.Дашдоржид хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Б.БАТЖАРГАЛ

АУДИТОР

М.УХААНБИЛЭГ

С.ТӨМӨРХУЯГ



2125040667



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 08 сарын 21 өдөр

Дугаар 24/223 НТАГ-2025/27-ШТА-ГА 1470309 Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2024 оны жилийн эцсийн байдлаар хугацаа хэтэрсэн 94.2 сая төгрөгийн төлбөрийн актын үлдэгдлийг барагдуулах шат дараалсан арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 6.3.6-д “санхүүгийн хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй,” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хугацаа хэтэрсэн төлбөрийн актыг барагдуулах ажлыг Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолд заасны дагуу зохион байгуулж, биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга Б.Мөнгөнтуулд хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Б.БАТЖАРГАЛ

М.УХААНБИЛЭГ

С.ТӨМӨРХУЯГ



2125040666

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/25


Чойбалсан хот

Г Тайлан баталгаажуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгөгдсөн албан шаардлагыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Нийслэл дэх төрийн аудитын газар, Дорнод аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Татварын газар, Цагдаагийн газар, Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргаа, Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газруудад тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Батжаргалд даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2125020004



Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Албан шаардлагын дүн /сая.төг/
1	Дорнод аймгийн ИТХ-ын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл	01/221 НТАГ-2025/27-ШТА-ГА	4.0
2	Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргаа	02/222 НТАГ-2025/27-ШТА-ГА	12.5
3	Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	03/223 НТАГ-2025/27-ШТА-ГА	94.2
Дүн			110.7

ХАВСРАЛТ:

Харилцан уялдаагүй хууль, тогтоомжийн заалт	
Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2-т “аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого” гэж заасан байна.	Зөрчлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураана. 4.1.3.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ зүйлийн 4.1.1 дэх хэсэгт заасан хөрөнгө, орлогоос хохирол нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ. 4.3.1 Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, зөрчлийн улмаас учирсан хохирол барагдуулах, хор уршгийг арилгах арга хэмжээнд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ . Тайлбар: Энэ бүлэгт заасан "эрх бүхий албан тушаалтан" гэж зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг ойлгоно.
Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2-т “аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого” гэж заасан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5-т “нийгмийн даатгалын сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ: нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэн, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг бууруулсан болон нуусан орлогод тооцсон алданги, торгууль ”
Зөрчлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураана. 4.1.3.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ зүйлийн 4.1.1 дэх хэсэгт заасан хөрөнгө, орлогоос хохирол нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ . 4.3.1 Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, зөрчлийн улмаас учирсан хохирол барагдуулах, хор уршгийг арилгах арга хэмжээнд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ. Тайлбар: Энэ бүлэгт заасан "эрх бүхий албан тушаалтан" гэж зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг ойлгоно.	Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4 “нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль” Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-ын 2.5.4. нийслэл, орон нутгийн авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийг тухай бүр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд ;
Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд. ...Зөрчлийн тухай хуулийн... ...14.4, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 5, 6, 7, 9 дэх хэсэг, 14.7, 15.1 дүгээр зүйл... ...заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.	Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-ын 2.5.4. нийслэл, орон нутгийн авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийг тухай бүр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд;

Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын байр, 4 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn